

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН СЭТГҮҮЛ

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

2014 ОНЫ 6 САР. №12 (070)

ЭДИЙН ЗАСАГ

ТАТВАР ТӨЛӨГЧ, ХУРААГЧ ХЭН
БҮХЭНД

УУЛ УУРХАЙ

ГАЗРЫН ТОС: АШИГ, ОРЛОГО,
ЭРСДЭЛ, БҮТЭЭМЖ

WWW.MONGOLIANECONOMY.MN

ФРИЙДЛАНДЫН МӨРӨӨР



ДЭЛХИЙН АВАРГЫГ ИЛҮҮ УХААЛАГ ТЕЛЕВИЗОРООР



32 инчийн ТВ бэлгэнд

УХААЛАГ ТЕЛЕВИЗОР худалдан авсан хэрэглэгч бүрт SAMSUNG, SHARP брэндийн 2014 оны шинэ загварын LED ТВ бэлэглэнэ

2014.06.11-07.15



MONGOLIA BUSINESS SUMMIT 2014

MONGOLIA BUSINESS SUMMIT 2014 WILL BE HELD ON
JUNE 19-21, UB, MONGOLIA



БИЗНЕСИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТ

2014.06.19-21
ИХ ТЭНГЭР ЦОГЦОЛБОР



Australia



Japan



Singapore



China



Jordan



South Korea



Germany



Netherlands



Taiwan



Hong Kong



Poland



United Kingdom



India



Russia



United States

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын сэтгүүлдийн эвлэлийн
“2013 оны Шилдэг сэтгүүл”

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр / 9999-4248

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал / 8800-6228

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Теренс Эдвардс

ЗӨВЛӨХ МЭРГЭЖИЛТЭН:

Лиззи Хүү

ОРЧУУЛАГЧ:

Р.Гантулга

ВЭБ РЕДАКТОР:

Б.Энхцэцэг

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Э.Зоригт

Б.Үүрийнтуяа

С.Батзаяа

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

ВЭБ МАСТЕР:

Н.Гал

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Барянжав / 9409-2904

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

М.Хишигтогтох / 9409-2906

“ECONOMY” ТВ СТУДИ

СЭТГҮҮЛЧ:

Ц.Соёлмаа

ЗУРАГЛААЧ:

Ш.Гантуул

КОМПЬЮТЕР ГРАФИКЧ:

Т.Баярсайхан

ХАЯГ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг.

VI хороо, Их сургуулийн гудамж.

AV center. 503 тоот

15160 Улаанбаатар,

Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

Утас/Факс: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

www.ubprint.mn



MONGOLIAN ECONOMY
ОНЛАЙН СЭТГҮҮЛ
mongolianeconomy.imedia.mn

АГУУЛГА

ЭДИЙН ЗАСАГ

- 8 Монгол дахин алдахгүй
- 10 Татвар төлөгч, хураагч хэн бүхэнд
- 14 Цементийн үйлдвэрийн эрин
- 15 Бодлогын хүү эцсийн сонголт уу
- 18 Тоон мэдээ

“ P10



БИЗНЕС

- 20 Роберт Фрийдланд ба өөдрөг үзэлтэн
- 22 Эдийн засгийн уналтын үеийн бизнесийн стратеги
- 26 Олон улсыг Монголоор “цэнэглэ”

УУЛУУРХАЙ

- 28 Ашигтай хувилбарыг нь сонго
- 30 Welcome back
- 31 Газрын тос: Ашиг, орлого, эрсдэл, бүтээмж
- 34 Цогтцэцийгээс Гашуунсухайт хүртэлх саарал амьдрал-4 Монгол уу, Хятад уу
- 36 Аюулгүй бас дахин аюулгүй
- 40 Хүмүүн цадиг

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Б.БЯМБАСАЙХАН Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, “Mongolian Economy” сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн

Б.БОЛД “Рио Тинто” компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажиллагаа эрхэлсэн Ерөнхийлөгч

С.БЭХБАТ ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга

Д.ЖАРГАЛСАЙХАН МIН группын ерөнхийлөгч

Ц.БАТСҮХ СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Ж.СҮНЖИДМАА “Пийбоди Энержи” компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер

Б.ТҮВШИНТӨГС Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал

Борлуулах цэгүүд:

“Интер ном”

“Цэцэг төв”

“Минж плаза”

“Алтантүлхүүр” номын дэлгүүр

“Номин” супермаркетийн бүх салбар

“Макс” супермаркетийн бүх салбар

“Фреско” супермаркет

BTSI супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн

“Grand plaza”

“Metro mall”

“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр дэх салбар

“Max mall” салбарууд

 facebook.com/Mongolian.
Economy

 twitter.com/EconomyMon-
golia

 youtube.com/user/Mongo-
lianEconomy

МОНГОЛД

Айлчлал

Ерөнхий сайд Н.Алтанхуяг өнгөрсөн сарын 23-25-нд Петербургийн олон улсын эдийн засгийн чуулга уулзалтад оролцсон. Тэрбээр энэ үеэрээ ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинтай уулзаж, хоёр орны улс төр, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх боломж, хоёр талын хооронд яригдаж ирсэн асуудлуудыг урагшлуулах талаар санал солилцсон юм. Мөн тус улсын зарим холбогдох албан тушаалтантай уулзан Монгол Оросын хамтарсан үйлдвэрүүдийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, харилцан ашигтай хамтран ажиллах, ураны салбарын хамтын ажиллагааны талаар ярилцжээ. Энэ нь хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж талууд үзэж байна.

Автозам

Нийслэлд өнгөрсөн онд автозамын 18 уулзварыг шинэчилсэн. Харин энэ жил 12 уулзварыг шинэчлэхээр болжээ. Тухайлбал, Энэбишийн өргөн чөлөө, Ахуйн үйлчилгээний уулзвар болон “Цэцэг” төвийн уулзварыг дөрвөн замын уулзвар болгон өргөтгөх аж. Ингэснээр автозамын ачаалал тодорхой хэмжээгээр буурна гэж албаныхан тооцоолжээ. Түүнчлэн хурдны зам дэд төслийн хүрээнд “Туул” болон “Сэлбэ” хурдны замын техник,

эдийн засгийн үндэслэл, байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийсэн байна. Энэ сарын 16-нд гүйцэтгэх компаниудтай гэрээ байгуулж, замын ажлыг эхлүүлэхээр болжээ.

Хууль

Монгол Улс дэлхийн худалдааны байгууллагын өмнө хүлээсэн үүрэг амлалтыг хэрэгжүүлэх, худалдааг зохицуулах, хөнгөвчлөх, дэмжих, хөгжүүлэх гээд гадаад, дотоодын худалдаатай холбогдсон харилцааг хуулиар зохицуулах шаардлага бий болоод байгаа. Тиймээс Засгийн газраас Худалдааны тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхээр болжээ. Манай улс өнгөрсөн хугацаанд дэлхийн 135 оронтой худалдаа хийжээ. Гэвч өнөөг хүртэл худалдааны талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогогүй, эрх зүйн зохицуулалт нь тодорхойг. Тиймээс Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, олон улсын хэмжээнд худалдаа хийх жишигт нийцүүлэх хэрэгцээ бий болсон байна.

“Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай”, “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн төслийг Засгийн газар боловсруулжээ. Ингэснээр огт илрээгүй байсан орлого, хөрөнгө ил гарч, тэдгээрт хууль тогтоомжийн дагуу татвар ногдох боломж бүрдэнэ гэж үзэж байна. Мөн

санхүүгийн болон татварын хуурамч тайлангуудыг хүү торгуульгүйгээр залруулж, зөв гольдиролд нь оруулахад бодитой үр дүн гарна гэж тооцоолсон аж. Хуулийн төсөлд татвар, нийгмийн даатгалаас гадна үл хөдлөх хөрөнгийн бүртгэл болон хуулийн этгээдийн, нягтлан бодох бүртгэл, хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар тусган өргөн хүрээг хамарсан зохицуулалт оруулж буй аж.

Газар тариалан

Манай улс энэ жил 373.5 мянган га талбайд тариалалт хийнэ. Үүний 304.5 мянган га-д улаан буудай, 15.5 мянган га-д төмс, хүнсний ногоо 8.3 мянган га-д, малын тэжээл 10.3 мянган га-д, тосны ургамал 24.1 мянган га-д тарина. Хаврын тариалалтад зориулан Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас худалдан борлуулах импортын үрийн буудайн үнийг 880-830, дотоодын үрийн үнийг 680 мянган төгрөгөөр тогтоож, 20 хувийн урьдчилгаатайгаар зээлээр олгож, намрын ургацаас нөхөн бүрдүүлэхээр шийдвэрлэжээ. Одоогоор улсын хэмжээнд 144.3 мянган га-д үр тариа, 3.7 мянган га-д төмс, хоёр мянган га-д хүнсний ногоо, 18.8 мянган га-д тосны ургамал тариалаад байна.

Хөдөө аж ахуй

“Өвлийн хүлэмжийн аж ахуй” байгуулахад “Чингис” бондоос нийт 27 орчим тэрбум төгрөг хуваарилжээ.

Нийт 80 орчим аж ахуйн нэгж саналаа ирүүлснээс 16 компанийн төсөл банкны шаардлагыг хангасан байна. Төрөөс энэ салбарыг дэмжсэнээр монголчууд өргөст хэмх, улаан лооль, амтат чинжүү, навчит байцаа зэрэг нарийн ногооныхоо хэрэглээг дотооддоо хангах боломж бүрдэх аж. Манай улсын нарийн ногооны нэг жилийн хэрэглээ 40 орчим мянган тн. Өнөөдрийн байдлаар 4600 тн-ыг нь дотооддоо тариалдаг юм байна. Тиймээс дотоодын хэрэгцээгээ бүрэн хангахын тулд хүлэмжийн аж ахуйг төрөөс дэмжихээр болжээ.

Газар өмчлөл

НИТХ-ын өнгөрсөн сарын 30-ны өдрийн тогтоолоор нийслэлийн иргэнд гэр бүлийн зориулалтаар өмчлүүлэх газрын байршлыг тогтоосон. Нийт 15.3 мянган га газраас хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж сургууль, цэцэрлэг, эмнэлэг, зам, дэд бүтэц, ногоон байгууламж барих газраа хасаад ойролцоогоор 160 мянган иргэн газар өмчилж авах боломжтой гэнэ. Ингэхдээ газар өмчилж авах саналаа цахимаар гаргасан иргэдийг л хамруулах юм байна. Тиймээс нийслэлийн Өмч, газрын харилцааны албанаас цахимаар газар өмчлүүлэх журмыг боловсруулж НИТХ-д өргөн бариад байгаа аж. Энэ сардаа багтаж журам нь батлагдах аж.

ДЭЛХИЙ ДАХИНД

АНУ-ын автомашины борлуулалт

АНУ-ын автомашины борлуулалт өнгөрсөн сард огцом өсчээ. Chrysler-ийн нийт борлуулалт 17 хувиар өссөн нь Jeep брэндийн шинэ загвар гаргаж, тухайн загварын борлуулалт 58 хувиар өссөнтэй холбоотой аж. Харин General Motors өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад өнгөрсөн сард борлуулалт нь 12.6 хувиар өсчээ. Мөн Ford –ын борлуулалт гурван хувиар нэмэгдсэн байна.

Евробүсийн инфляци

Евробүсийн инфляци өнгөрсөн дөрөвдүгээр сард 0.7, өнгөрсөн сард 0.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байсныг Financial Times мэдээлжээ. Шинжээчид өнгөрсөн сард 0.7 хувиар буурах болов уу гэсэн таамаг дэвшүүлээд байж. Энэ нь мөн Европын Төвбанкинд мөнгөний бодлогоо улам зөөлрүүлэх тал дээр шахалт үзүүлж буй хэрэг аж. Инфляци буурсан шалтгаануудын нэг нь хүнсний барааны үнэ хямдарсантай холбоотой юм байна.

БНХАУ-ын үйлчилгээний салбар

Өнгөрсөн сард Хятадын үйлчилгээний салбар хурдацтай өссөн нь сүүлийн зургаан сарын дээд түвшиндээ хүрсэн үзүүлэлт байв. Өнгөрсөн дөрөвдүгээр сард үйлдвэрийн бус худалдан авагч менежерийн индекс (non-manufacturing Purchasing Managers' Index)-ээр 54.8 оноотой

гарчээ. Харин өнгөрсөн сард 55.5 болж өссөн байна. Үүний өмнөхөн тус улсын Засгийн газраас өнгөрсөн сард аж үйлдвэрийн салбар он гарсаар хамгийн хурдацтай өссөн талаар мэдээлээд байсан юм. Барилга, нисэхийн салбарыг хамарч буй үйлчилгээний салбар нь Хятадын эдийн засгийн 43 хувийг эзэлдэг аж.

Японы хэрэглэгчийн үнийн индекс

Японы хэрэглэгчийн үний индекс өнгөрсөн дөрөвдүгээр сард маш их нэмэгдэж, оны өмнөх мөн үеийнхтэй харьцуулахад 3.2 хувиар өсчээ. Энэ нь сүүлийн 23 жилд байгаагүй өндөр өсөлтөд тооцогдож буй. Үүний шалтгаан нь өнгөрсөн дөрөвдүгээр сарын 1-нд борлуулалтын татварыг таваас найман хувь болгон нэмэгдүүлсэнтэй холбоотой. Тус улс хорь орчим

жилийн турш дефляци, үнийн бууралтын эсрэг тэмцээр ирсэн. Бодлого тодорхойлогчид энэхүү байдлыг дуусгавар болгох нь эдийн засгаа сэргээх гол тулгуур юм гэжээ.


ОХУ-ын ДНБ

ОХУ-ын ДНБ-ий өсөлт энэ онд 0.5 хувь, ирэх онд хоёр хувь болно хэмээ тус улсын Эдийн засгийн хөгжлийн сайд Алексей Улюкаев хэлжээ. 2015-2017 онд дунджаар 2.5 хувиар өсөх болно хэмээн Азарбайжаны Бакуд хэлснийг нь Интерфакс мэдээлсэн байна. Орос Хятадтай байгалийн хий нийлүүлэх гэрээг өнгөрсөн сард байгуулсан. Энэ нь ирэх оны ДНБ-ий өсөлтөд 0.3-0.4 хувийн өсөлт авчрах боломжтой гэснийг мөн Итар-Тасс мэдээлжээ. Тэрбээр 55 тэрбум ам.долларын хөрөнгө

оруулалт татах гэрээ, хэлцэл хийх төлөвлөгөөтэй байгаа аж.

Австралийн эдийн засаг

Австралийн эдийн засаг энэ оны эхний улиралд таамаглаж байснаас илүү өсчээ. Өнгөрсөн оны сүүлийн улиралтай харьцуулахад 1.1 хувь болж өссөн нь экспорт болон дотоодын хэрэглээ өссөнтэй холбоотой аж. Ихэнх шинжээч 0.9 хувь байх болов уу гэж таамаглаж байв. Харин жилийн өсөлтийн түвшингээр 3.5 хувь буюу сүүлийн хоёр жил байгаагүй өндөр өсөлт болжээ. Гэхдээ тус улсын эдийн засаг уул уурхайн салбараас хэт их хамааралтай болохыг зарим шинжээч хэлж буй. Эхний улирлын өсөлтийн 80 орчим хувийг уул уурхайн салбар эзэлснийг тус улсын Статистикийн хоороноос мэдээлжээ. ■



ОНЦЛОХ

МОНГОЛ ДАХИН АЛДАХГҮЙ

Б.ЭНХЦЭЦЭГ

Монголын нөхцөл байдал хүндэрснийг нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд тодорхой харуулж буй. Одоогийн нөхцөл байдал Монголыг сэргэх эсэхэд эргэлзээ төрүүлж байна гэх. Гэвч Монгол шиг нөөц бололцоотой оронд асуудал түр зуурынх байх бүрэн боломж бий. Монголын эдийн засгийн тулганд бадамласан гал унтраагүй харин нурамласан нь өсөлтийн хурд л саарсан дохио.

Энэ сарын эхээр Монголбанк гаднын хөрөнгө оруулалтын хэмжээ энэ жилийн эхний дөрвөн сард өмнөх оны мөн үетэй нь харьцуулахад 350 сая ам.доллар болж 64 хувь буурсан талаар мэдээллээ. Энэхүү хөрөнгө оруулалтын нийт дүнгээс багцын хөрөнгө оруулалтыг салгаж авч үзвэл шууд бус хөрөнгө оруулалтын ашиг өнгөрсөн оны мөн үеэс 342 сая ам.доллараар нэмэгдсэн дүнтэй байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай шинэ хууль өнгөрсөн оны арваннэгдүгээр сараас хэрэгжиж эхэлсэн. Тэгвэл хууль хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2013 оны сүүлийн хоёр сарын гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг энэ оны эхний хоёр сарынхтай харьцуулбал 3.1 хувиар нэмэгдсэн байна. Мөн түүнчлэн 2014 оны эхний улиралд 82 гадаадын хөрөнгө оруулалттай компани манай улсын дансанд шинээр бүртгүүлээд байгаагаар Гадаадын хөрөнгө оруулалтын газар мэдээлж буй. Эдгээр компанийн хоёр нь өнөөдрийн байдлаар Татварын тогтвортой байдлын гэрээний эрхээ баталгаажуулаад байгаа нь үйл ажиллагаагаа бүрэн эхэлсэн гэсэн үг.

Хөрөнгө оруулалтын шинэ хууль нь хувийн хэвшлийнхэнд шинээр бизнес эхлүүлэхэд ямар ч зөвшөөрөл, хязгаарлалтгүй болгосны дээр валютын хараа хяналт тулгахгүй. Түүнчлэн татварын олон төрлийн хөнгөлөлт эдлэх, татварын тогтвортой байдлын 5-22 жилийн хугацаатай

гэрээ байгуулах боломж бүрдүүлсэн. “Хоган Ловеллс” хуулийн фирмийн партнер Крис Мелвилл “Бид энэ хуулийг ерөнхийдөө олон талаараа эерэг хууль болсон гэж үзэж байгаа. Гэвч өнөөдөр ч тус хуулийн хэрэгжилтийн задаргаа байхгүй, хууль хэрэгжихэд дутаж буй зохицуулалтуудыг яах нь тодорхойгүй байгаа нь асуудал хэвээр” гэсэн юм.

Харин нөгөө талаас тус хуулинд заагдсан 100 мянган ам.долларын гадаадын хөрөнгө оруулалтын босго нь ЖДҮ-ийн санхүүжилт татах боломжийг боомилж буй. Гаднын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, хөрөнгө оруулагч орж ирье гэхэд компанийн нийт хөрөнгийн хэмжээ нь 100 мянган ам.доллараас илүү байх ёстой бус тус хөрөнгө оруулалтад оролцож буй хөрөнгө оруулагч бүр 100 мянган ам.доллараас дээш мөнгийг оруулах нөхцөлтэй тулж буй, хуулиараа. Хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын сурталчилгаа, зөвлөх үйлчилгээний газрын дарга Д.Ирмүүн “Давуу тал нь олон улсын хөрөнгө оруулалтын хуультай нийцэж байна. Харин сөрөг тал нь өмнөх хуультай харьцуулахад хэтэрхий ерөнхий утгатай. Жижиг, дунд үйлдвэрлэгчид хөрөнгө оруулалт татах боломж муу байна” гэсэн.

Тэгвэл өнөөдөр ЖДҮ-ийг дэмжих нийслэл орон нутгийн олон төрлийн сан, хөтөлбөрүүд бий болж буй. Тухайлбал, Нийслэл энэ оны төсөвтөө бичил бизнесийг дэмжих зорилгоор 15.2 тэрбум төгрөгийг төсөвлөсөн. Түүнчлэн ЖДҮ-ийг дэмжиж, ажлын байр нэмэгдүүлэх, импорт орлох, экспорт дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор энэ сарын 1-нээс хойш импортлосон ЖДҮ-ийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулийг саяхан баталчихлаа. Харин том хэмжээний төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчид татвараа хэсэгчлэн төлөхийг шинэ хуулиар зөвшөөрчээ. Энэ нь гаднын хөрөнгө оруулалттай, дотоодын бүх компаниудад хамаатай. ▶

Doing business in Mongolia Монголын бизнесийн орчин

Улс	Нийт татвар (ашигт эзлэх %)	Ажлын байрны цомхолтгол (Цалин 7 хоноогоор*)	Хөрөнгө оруулагчийн хамтгаалалт (Дэлхийн үзүүлэлт)	Бүтээн байгуулалт хийх Зөвшөөрөл авах		Гэрээний хэрэгжилт		Худалдаа (Импорт)		Авилгал (Дэлхийн үзүүлэлт)
				Хугацаа (өдрөөр)	Зардал (орлогод эзлэх хувь)	Хугацаа (өдрөөр)	Зардал (хувиар)	Хугацаа (өдрөөр)	Зардал (ам. доллараар)	
ОХУ	50.7	8.7	115	297	89.0	270	13.4	21	2810	127
БНХАУ	63.7	23.1	98	270	344.7	406	11.1	24	615	80
Монгол	24.6	4.3	22	186	7.6	314	30.6	50	2950	83
Их Британи	34.0	3.1	10	88	66.0	437	39.9	6	1050	14


▶ Монголын хөрөнгө оруулалтын орчныг тодорхойлох зарим үзүүлэлтийг бусад улсынхтай харьцуулаад үзье. Хувийн хэвшилд ногдуулдаг нийт татварын хувь хэмжээ гэхэд бусад улсынхаас 15 дахин бага буюу 24.6 хувь байна. Тэгвэл барилгын зөвшөөрөл авах зардлын компанийн орлогод эзлэх хувь ердөө 7.6 хувь байна. Энэ хэмжээ Хятадад 344, Испанид 172 гаруй хувиар хэмжигдэж байна. Харин авлигын индекс болон худалдаагаар төдийлэн сайн үзүүлэлт манайд байдаггүйг “Doing business 2014” олон улсын тайлан харуулжээ. Тухайлбал, импортын зардал чингэлэг тутамд 2950 ам.доллар, тээвэрлэлтийн хугацаа 50 өдөр байгаа нь олон улстай харьцуулахад доод тал нь хоёр дахин өндөр байгаа юм. Саяхан олонд ил болсон “Baseline Profitability Index” гэх үзүүлэлтээр Монгол Улс 10 дугаар байрт орсон нь хөрөнгө оруулалтын ерөнхий дүр зургийг илтгэх сүүлийн үеийн үзүүлэлт. Тус үнэлгээг гаргахдаа гол найман үзүүлэлтийг чухалчилсан нь Эдийн засгийн өсөлт, Санхүүгийн тогтвортой байдал, Аюулгүй байдал, Авлигын түвшин, Засгийн газрын бизнес дэх оролцоо, Орон нутгийн бизнесүүдтэй түншлэх боломж, Хөрөнгийн хяналт, Ханшийн түвшин зэрэг аж.

Хөрөнгө оруулагчдын төрөлжилт

Өмнө нь манай улсын зах зээлд АНУ болон Хятадын хөрөнгө оруулагчид давамгайлж ирсэн. Тэгвэл өнөөдөр гадаадын хөрөнгө оруулалтын хувьд газарзүйн байршил нэлээд төрөлжиж, Зүүн Ази, Япон, Европын холбооны орнууд хүч түрэн орж ирж байгаа аж. Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар “Шинээр баталсан хөрөнгө оруулалтын хууль үр өгөөжөө өгөөд эхэлсэн. Сүүлийн хоёр сарын хугацаанд долоо хоног бүр хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт болж байна. Салбарын хувьд зөвхөн уул уурхай бус хөдөө аж ахуй, газар тариалан, ногоон хөгжилд хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байна” гэсэн юм.

Европ Азийн эдийн засагтай илүү нягт хэлхэлдэж, эдийн засгаа тус тивийн өсөж буй орнуудтай уяж, хөгжлийн эрчээ түргэсгэхээр сонирхож буй өнөө үед Монгол хараанаас нь мултарсангүй. Тиймээс ч Европын зочид ээлж дараалан Монголыг зорьж, гадаадын хөрөнгө оруулагчдын цувааг төрөлжүүлж байна. Он гарсаар гаднын хөрөнгө оруулагчид манай улсыг зорин ирж, томоохон хэмжээний уулзалтууд нэлээд зохион байгуулагдсан бөгөөд тэд тодорхой салбаруудыг цохон хөрөнгө оруулах сонирхолтой байгаагаа илэрхийлж, нөхцөл байдалтай танилцаад явсан. Тухайлбал, өнгөрсөн саруудад Австриас ирсэн бизнесийнхэн эрчим хүчний салбарыг сонирхож байсан бол, тайваньчууд үйлдвэрлэлийн өндөр технологиудыг Монголд нэвтрүүлэх талаар ярилцаж, хаягдал усыг дахин боловсруулах менежментийн тал дээр хамтарч ажиллаж болох бодит саналаа хэлээд явсан. Тэд мөн Тайванийн экспорт, импортын EXIM банкт манай хувийн хэвшлийнхэн шууд харилцаж, доогуур хүүтэй урт хугацаатай зээл авах боломж буйг хэлсэн. Хамгийн сүүлд Испанийн 30 гаруй хөрөнгө оруулагч манай улсад ирж гурван өдрийн чуулга уулзалтад оролцоод буцсан. Тэдний зүгээс манай улстай ногоон хөгжил, ногоон технологиор хамтран ажиллах сонирхол их гэж байсан. Тухайлбал эрчим хүч, дэд бүтэц, ус цэвэршүүлэх, хөнгөн үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалт бүрдүүлэх боломжтой гэдгийг

ГХО. Нэгдүгээр улирал



2014 эхний дөрвөн сарын байдлаар

Гадаадын хөрөнгө оруулалт	<ul style="list-style-type: none"> ГШХО 350 сая ам.доллар болж, 64 хувиар буурсан Багцын ХО 342 сая ам.доллараар нэмэгдсэн
Гадаадын хөрөнгө оруулалттай шинэ компанийн тоо	82
Татварын тогтвортой байдлын гэрээ байгуулсан төслүүд	2

эндээс харж болохоор байлаа. Тэгвэл хөрөнгө оруулагчдын цуваа ингээд дууссангүй. Энэ сард Энэтхэгийн 30 гаруй хөрөнгө оруулагч Монголд ирэх бол долдугаар сард Хятадын 200 гаруй хөрөнгө оруулагч оролцсон томоохон чуулган Монголд болно. Мөн түүнчлэн япончуудтай хамтран Төр хувийн хэвшлийн форумыг долдугаар сард, АНУ-ын Худалдааны байгууллагатай хамтран Forbes сэтгүүлээс “Fortune 500” жагсаалтад багтдаг нэлээд Америкийн компанийг Монголд авчрахаар холбогдох байгууллагууд ажиллаж байгаа нь гаднын хөрөнгө оруулалт сэргэх урьдач нөхцөл бийг гэрчилж буй. Хөрөнгө оруулагчдын сонирхлын ерөнхий чиг хандлагыг харахад тэд уул уурхай гэхээсээ илүүтэй Хөдөө аж ахуй, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, сэргээгдэх эрчим хүчний салбарыг түлхүү сонирхож байгаа юм. Испанийн “Isolux Corsan” компанийн бизнес хөгжүүлэлтийн менежер Есүл Родригез “Энэ удаад ямар төслүүд дээр хамтарч ажиллаж болох талаар илүү ихийг мэдэхээр Монголд ирлээ. Ер нь бидний гол сонирхол дэд бүтэц тэр дундаа зам, төмөр замын төслүүд байгаа. Ойрын ирээдүйд төсөл хөтөлбөрөө тодорхой болговол салбараа нээж, үйл ажиллагаагаа эхэлнэ” гэж хэлж байсан юм.

Хөрөнгө оруулалтын урсгалыг сэргээж болно. Сэргэж ч буй. Монголд үзүүлэх гаднынхны итгэл шалдаа буучихаагүй байхад алттай авдран дээр суусан эздийн итгэл, зүтгэл унтарч болох уу даа. Бусдад итгэх зориг төрүүлэхийн тулд итгүүлэх сэтгэл, өөдрөг үзэл, зөв шийдвэр л чухал. ■



Шог зургийг А.Амарсайхан

ТАТВАР

ТАТВАР ТӨЛӨГЧ,
ХУРААГЧ ХЭН БҮХЭНД

Монгол Улсад 2007-2012 онд татварын I үе шатны шинэчлэл хийгдэж, “дөрвөн 10”-ын бодлого буюу /НӨАТ, ААНОАТ, ХХОАТ, НДШ/ Азид төдийгүй дэлхийд хамгийн багад тооцогдох татвартай орны тоонд орсон билээ. Эдийн засгийн хурдацтай хөгжилтэй холбоотойгоор Шинэчлэлийн Засгийн газраас Татварын II үе шатны багц хуулийн өөрчлөлтийг 2014-2017 онд хийх зорилттой ажиллаж байна. Үүнтэй холбоотой эхний хуулийн төслүүд саяхан УИХ-д өргөн баригдсантай уялдан УИХ, Засгийн газар, хувийн хэвшлийн

төлөөллийг оролцуулсан хоёр ч удаагийн нээлттэй хэлэлцүүлэг болоод байна. Эхнийх нь өнгөрсөн сарын 30-нд Төрийн ордны “Иргэний танхим”-д УИХ дахь татварын шинэчлэлийн Ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн С.Баярцогтын хөтөлж явуулсан “НӨАТ болон Худалдааны албан татвар” сэдэвтэй, хоёр дахь нь энэ сарын 10-нд Засгийн газраас “Шинэчилж шийдье” нээлттэй хэлэлцүүлэг хийсэн. Татварын хэлэлцүүлэгт хувийн хэвшлийнхэн нэлээд идэвхтэй оролцож санаа бодлоо хэлж байгаа юм. УИХ-д өргөн бариад байгаа НӨАТ-ын

босыг 50 сая төгрөг болгож өндөрсгөх тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг ид дундаа өрнөж байна. Хууль хаврын чуулган тарахаас өмнө эцэслэн батлагдах эсэх нь одоогоор тодорхойгүй байгаа юм. Харин Монголын бизнесийн зөвлөлийн Татварын ажлын хэсгийн ахлагч “Делойтт онч аудит” компанийн захирал Д.Ончинсүрэнгээр ахлуулсан олон бизнесмэн оролцож, удаан ярилцаж, тогтон судалж бичсэн НӨАТ-ын тухай нийтлэлээ манай сэтгүүлд хаяглан ирүүлсэнийг бүрэн эхээр нь хүргэж байна. НӨАТ-ын босго 10 байх ёстой, 50 ▶

► **байх ёстой, огт НӨАТ-гүй болъё, Худалдааны татвар хэрэгтэй гэх зэргээр олон талаас янз янзын байр суурь сонсогдож, толгой эргүүлсэн зүйл болж байгаа энэ үед уг нийтлэл татвар төлөгчид болон хурааж улсын төсөв бүрдүүлэгч аль аль талд нь санаа авах, бодит үндэслэл тооцоотой үнэнийг өгүүлсэн НӨАТ-ын практик-онолын аль алиныг нь харсан сайн нийтлэл юм.**

НӨАТ гэж юу вэ?

Онолын хувьд НӨАТ-ыг үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн бараа, ажил үйлчилгээний нэмүү өртөгт ногдуулдаг. Өөрөөр хэлбэл, хэрэглээний татвар бөгөөд НӨАТ төлөгч нь бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авч буй эцсийн хэрэглэгч байдаг. Үйлдвэрлэгч эсвэл борлуулагч нь НӨАТ-ыг эцсийн хэрэглэгчээс хураан авч улсад тушаах үүрэгтэй байдаг ба НӨАТ ногдуулалт, төлөлтийн тайлан гаргаж, эцсийн төлбөр тооцоог гүйцэтгэнэ. Тайлан гаргагч аж ахуйн нэгж нь борлуулалтад ногдуулсан НӨАТ-өөс, өөрийнхөө худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг хасч үлдсэн хэсгийг нь улсын төсөвт төлдөг. Хэрэв худалдан авалтад төлсөн НӨАТ нь борлуулалтад ногдуулсан НӨАТ-аас илүү бол зөрүүг улсаас буцаан авах ёстой. Харин эцсийн хэрэглэгч нь энэхүү татвараа буцаан авалгүйгээр татвар төлөх ёстой. Анх 1920-иод онд Германы Вилхелм вон Сиененс гэгч үйлдвэрийн эзэн НӨАТ-ыг санаачилсан ба 1960-аад оны сүүлээс уг татвар дэлгэрсэн байна. Харин Монгол Улс нь 1998 оноос НӨАТ-ын тухай хуулийг мөрдөж эхэлсэн бөгөөд харин 2006 оны долдугаар сард дахин шинэчлэн баталсан одоогийн хууль 2007 оны нэгдүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Түүнээс хойш хуулийг сайжруулах зорилгоор арав гаруй өөрчлөлт хийсэн ба дээд шүүхийн хэд хэдэн тайлбар гаргасан боловч НӨАТ-ын хууль, түүний хэрэгжилтийг хөрөнгө оруулагчид үйлдвэрлэгч, аж ахуйн нэгжүүдэд нэмэлт татварын дарамт бий болгосон, хэрэглээний татварын зорилгоо гүйцэтгэхгүй байна гэж шүүмжилдэг.

НӨАТ манай улсад тохирох уу

НӨАТ бол жижиг улс оронд нэн тохирсон, улсын төсөв бүрдүүлэхэд хамгийн үр ашигтай татвар гэгддэг. НӨАТ-ын орлогыг хураах процесс нь татварын байгууллагын хараа, хяналтан дор байж, улсын өмнөөс аж ахуйн нэгжүүд НӨАТ-ыг борлуулалтаа ногдуулж, эцсийн хэрэглэгчээс хурааж, татварын төсөвт тушааж бас тайлагнадаг тул хамгийн үр дүнтэй байдаг. Шинэ Зеланд Улс НӨАТ-ыг хамгийн үр дүнтэйгээр хэрэгжүүлсэн бөгөөд ихэнх жижиг улс орнууд НӨАТ-ын үр ашгийг тооцоход өргөн хэрэглэгдэг шалгуур болох C-efficiency-гээр хэмжихэд өндөр оноо авдаг. Харин хэр шударга татвар вэ гэдгийг олон хүмүүс асуусаар ирсэн. Орлого ихсэх тусам хэрэглээндээ зарцуулах хувь багасдаг учраас тэгш татвар маань тэгш биш болж, орлого багатай иргэдэд хүнд тусаж байгаа нь анзаарагддаг. Урьдчилан тооцоогүй, тааламжгүй үр дагаврыг арилгахын тулд Тухайлбал, Австрали болон Канад улсад байр орон сууц авахад НӨАТ-аас чөлөөлөх зэрэг арга хэмжээг авсан. Манай улсын хувьд зарим мах гэх мэт өргөн хэрэглээний бараа, эрүүл мэндийн үйлчилгээ болон амьдран суух зориулалттай орон сууцны борлуулалтыг НӨАТ-өөс чөлөөлдөг.

Гэтэл сүүлийн үед НӨАТ-ын талаар эсрэг тэсрэг яриа хэлэлцүүлэг их гарч байна. Яагаад? НӨАТ нь эцсийн дүндээ аливаа улс орны иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг тайлан баланст оруулах, сүүдрийн эдийн засаг буюу хар зах зээлийг багасгах, татварын мөнгөний урсгалыг төр өөрийн хяналтад байлгаж, хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагыг санхүүгийн цэгцтэй тогтолцоонд оруулах механизм юм. Харин Монгол улсын НӨАТ-ын хуулийн бүтэц, зохицуулалт сайтар боловсруулагдсан боловч хэрэгжүүлэх арга аргачлал тодорхой зохицуулагдаагүй тул нэг талаас хууль хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтан өөрийн үзэмжээр тайлбарлан, аж ахуйн нэгжүүдэд татварын нэмэлт дарамт учруулах, нөгөө талаас хувь хүн, аж ахуйн нэгж байгууллага НӨАТ ногдуулахаас

зайлсхийх, НӨАТ-ын хасалтыг буруугаар ашиглах зэрэг хуулийг дагаж мөрдөхгүй байх үзэгдлүүд гарсаар байна. Хуулийн хэрэгжилтэд гарч буй энэхүү доголдол нь аж ахуйн нэгжүүдэд дарамт үзүүлж, тэдгээрт бухимдал бий болгосноор бизнесийн таагүй орчинг бүрдүүлэх боллоо. НӨАТ-ыг зөвхөн эцсийн хэрэглэгч төлөх ёстой байтал хуулийг зөрчсөн буруу тайлбар, дарамт шахалтаар ихэвчлэн үйлдвэрлэгчид болон борлуулагчид өөрөө төлөх тохиолдол олширсоор байна. НӨАТ-ын буцаан олголт болон өөрийнх нь зохицуулалтын сонгомол аргаар нь хяналтыг хэрэгжүүлж, татварыг зөв хэрэгжүүлбэл өндөр үр ашигтай татварын орлогын эх үүсвэр гэдэг нь олон улс орны туршлагаас харагддаг.

НӨАТ-ын загварт уу эсвэл хуулийн хэрэгжилтэд үү?

Асуудлын гол шалтгаан нь загвартаа бус харин хуулийн буруу хэрэгжилтэд байна. Хуулийн хэрэгжилтийн дараах доголдлууд нь татварын дарамтыг бий болгож улмаар манай улсад НӨАТ хэрэггүй гэдэг маргааныг үүсгэх гол шалтгаан болоод байна.

- **Буцаан төлөгдөхгүй НӨАТ-ын нэр төрөл олширсоор байна**

Сүүлийн үед олон улс хоорондын үйлчилгээнд НӨАТ ногдуулж эхэлсэн ба уг татварыг төлсөн Монгол Улсын аж ахуйн нэгжүүд НӨАТ-ын хасалтыг хийлгэж чадахгүй байгаа нь буцаан төлөгдөхгүй бас нэгэн татварыг бий болгож, НӨАТ-ыг аж ахуйн нэгжүүдэд үүрүүлж байгаа нь хуулийн зорилгод нийцэхгүй байна. НӨАТ-ын тухай хуульд хуулийн үйлчлэх хүрээ нь зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйлдвэрлэсэн буюу борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулахаар заасан байдаг боловч гадаад улс оронд гүйцэтгэсэн ажил үйлчилгээнд НӨАТ ногдуулж эхэлсэн. НӨАТ-ын тухай хуульд энэхүү заалтыг маш ойлгомжтойгоор “Иргэн, хуулийн этгээдийн импортолсон буюу экспортолсон бараа, түүнчлэн Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн буюу борлуулсан бараа, гүйцэтгэсэн ►

► ажил, үзүүлсэн үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулахад энэ хууль үйлчилнэ” гэж заасан байдаг билээ.

Худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг хасуулж чадахгүй байх, илүү төлсөн НӨАТ-ыг буцаан авч чадахгүйгээс бий болдог татварын нэмэлт дарамт нь аж ахуйн нэгжийг мөнгөн гүйлгээний дутагдалд оруулж, хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа зогсооход хүргэдэг сөрөг талтай.

• НӨАТ-ын чөлөөлөлт

Сүүлийн жилүүдэд НӨАТ-ын хуулинд орсон 10 гаруй удаагийн өөрчлөлтөөр чөлөөлөгдөх бүтээгдэхүүн болон үйлчилгээний жагсаалт улам уртсаж байгаа бөгөөд үүнд уул уурхайн эцсийн бүтээгдэхүүнээс бусад бүх ашигт малтмал, тэр дундаа алт орж байгаа. Энэхүү чөлөөлөлт нь дээрх бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг эцсийн хэрэглэгч болгон тэдний нийт худалдан авалтын үнийн дүнгийн 10 хувиар татвар нэмж ногдуулж байгаа гэсэн үг. Өндөр өртөгтэй уул уурхайн салбарын гадаад, дотоодоос авч буй бараг бүх худалдан авалтад НӨАТ ногддог тул уул уурхайн бүтээгдэхүүн НӨАТ-аас чөлөөлөгдсөнөөр НӨАТ нь шууд нэмэлт зардал болон хувирч байна.

НӨАТ-аас чөлөөлөгдсөн жижиг уул уурхайн компаниуд зардлаа багасгахын тулд НӨАТ ногдуулдаггүй бэлтгэн нийлүүлэгчдээс худалдан авалт хийхийг эрмэлзэх ба энэ нь далд эдийн засгийг дэвэргэж байгаа билээ. Тоног төхөөрөмж, түүхий эдийг импортлоход гаалийн татвар болон НӨАТ төлөх ёстой, гаалийн авлига НӨАТ-ын чөлөөлөлттэй холбоотой байж болох уу гэдгийг судлах ёстой асуудал.

Сүүлийн үед тодорхой салбаруудыг дэмжиж тэдгээр салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн импортолсон тоног төхөөрөмжийг НӨАТ-ын чөлөөлөлтөд хамруулах болжээ. Энэ нь тэдгээр тоног төхөөрөмжийг Монгол Улсад худалдан борлуулах эрхтэй дистрибуторуудын бизнесийг хаасан халтай чөлөөлөлт болсон.

Татварын дэмжлэгийг тодорхой салбаруудад үзүүлэхийг буруушаагаагүй боловч НӨАТ-ын буцаан олголтын механизмыг шуурхай болгож, аж ахуйн нэгжүүдийн илүү төлсөн НӨАТ-ыг хуулийн

хугацаанд буцаан олгож хуулиа сайтар хэрэгжүүлсэнээр хөрөнгө оруулагчдад ээлтэй орчин бий болж, ирээдүйн эдийн засгийн өсөлт, ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болох юм.

• Илүү төлсөн татварыг буцаан олгохгүй, удаашруулж байгаа нь үйлдвэрлэгчид, хөрөнгө оруулагчдыг мөнгөн урсгалын хямралд хүргэж байна

Хөрөнгө оруулагчид, үйлдвэрлэгчдийн илүү төлсөн НӨАТ-ын буцаан олголтыг хуулийн хугацаанд төлөхгүй харин улс төсөвтөө эргэлдүүлж байгаа нь бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтанд огт дэмжлэг болохгүй байна. НӨАТ-ын буцаан олголт бол НӨАТ-ын системийн үндсэн элемент боловч буцаан олголтыг улсаас цаг тухайд нь олгохгүй байгаа нь аж ахуйн нэгжүүд илүү төлсөн НӨАТ-ыг өөр татварын өрөнд суутгаж дуусталаа хэдэн жилээр хадгалж, мөнгөн гүйлгээний дутагдалд ордог. Ялангуяа бүтээн байгуулалтын шатандаа ихээхэн хэмжээний худалдан авалт шаардагддаг уул уурхай, барилга, болон дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулагчдад татварын нэмэлт дарамт хамгийн ихээр мэдрэгдэж байгаа ба эдгээр бүтээн байгуулалтын төслүүд зогсоход хүргэх эрсдэлтэй байна. НӨАТ-ын тухай хуульд аж ахуйн нэгжийн илүү төлсөн НӨАТ-ыг 1. Ирээдүйн төлөх НӨАТ-аас суутгах 2. Бусад төлөх татвараас хасан тооцох 3. Буцаан олгоно гэж заасан байдаг боловч бусад татварын өрөнд суутгуулах эсвэл буцаан төлөгдөх хүртлээ эхлээд буцаан олгогдох татварын дүнг баталгаажуулах хяналт шалгалтыг эхлэхийг хүлээж дараа нь тэдгээр шалгалтыг дуусахыг хүлээж хамгийн сүүлд улсын төсвөөс төлөгдөхийг нь хүлээж, хөөцөлдөн хэдэн арван сараар үргэлжилсэн, хүч хөдөлмөр зарцуулсан ажил болдог.

• НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх босго

НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх босго нь хэдэн төгрөг байлаа ч хэдэн хэдэн сөрөг үр дагавартай. Тухайлбал, манай хуулийн босго болох 10 саяас дөнгөж илүү гарсан аж ахуйн нэгж НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх шаардлагатай болох бөгөөд НӨАТ-ын падаан бичих, тайлан тооцоо гаргах, сар бүр тайлан тушаах, хяналт шалгалтад хамрагдах зэргээр

хуулийг хэрэгжүүлж мөрдөхийн тулд ихээхэн өртөг зардал, хүч чармайлт гаргадаг бол нөгөө талаас 10 саяас доош орлоготой компаниуд НӨАТ төлөгчөөр бүртгүүлсэн компаниудтай харьцуулахад хамаагүй ялгаатай үнийн өрсөлдөх чадвартай болдог.

Түүнчлэн 10 саяын босгод хүрээгүй тул НӨАТ төлөгчөөр бүртгүүлэхгүй бөгөөд худалдан авалтад төлсөн НӨАТ-өө буцаан авах боломжгүй болно гэсэн үг. Энэ нь зөвхөн жижиг аж ахуйн нэгжүүдэд төдийгүй томоохон төсөл хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүд бүтээн байгуулалтын шатандаа төлсөн НӨАТ-ыг хасуулж чадахгүйгээс нэмэлт татварын дарамтад ордог. Жишээлбэл уул уурхайн хайгуул хийж байгаа компани нь орлогогүй байдаг учраас НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх үндэсгүй бөгөөд түүний худалдан авалтадаа төлсөн НӨАТ нь шууд нэмэлт зардал болдог. Түүнчлэн худалдаа, үйлчилгээний жижиг компаниуд худалдан борлуулахаар импортолсон бараа болон түүхий эд материалдаа төлсөн НӨАТ-ыг буцаан авахгүй болох юм. Иймээс уг татварын босгыг нэмэгдүүлэхээр ярилцаж буй энэ үед босгыг хэт өндөр тогтоосноор босгоос доогуур орсон, НӨАТ төлөгчөөр бүртгүүлээгүй аж ахуйн нэгжүүд худалдан авалтадаа төлсөн НӨАТ-ыг хасуулж чадахгүй болсоноор үүрэх татварын нэмэлт зардлыг тооцож үзэх ёстой.

• Татварын хураалт, хяналт шалгалтын дутагдалтай тал

НӨАТ нь үйлдвэрлэлийн, үйл ажиллагааны шат дамжлагын ажил гүйлгээ бүрт НӨАТ ногддог ба худалдан авагч аж ахуйн нэгж нь худалдан авалтын НӨАТ-өө заавал хасуулдаг тул бэлтгэн нийлүүлэгч тал нь татварыг ногдуулахгүй, цуглуулахгүйгээс татварын орлого алдах, буурах эрсдэлийг бууруулдаг “өөрөө өөрийгөө хянадаг” татвар юм.

Гэтэл манай улсын хувьд цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулж хураалт, хяналтыг хэрэгжүүлдэг нөгөө талаас татвар төлөгч нь татварын албаны урт удаан хугацааны хэцүү шалгалтыг давж байж НӨАТ-ын татварын илүү төлөлтийг баталгаажуулж байна.

Татварын системд НӨАТ-ын энэхүү өөр өөрийгөө хянадаг механизмыг үр дүнтэй ажиллуулахын тулд урьдчилан ►

▶ дугаарласан НӨАТ-ын падааныг ашигладаг ба татварын алба аж ахуй нэгж бүрт хяналттайгаар тараадаг. Гэтэл уг баримт бүхий хяналтын аргыг үр дүнтэйгээр ашиглаж хэрэгжүүлж чадахгүй байгаагийн сацуу падаан нэг бүрийг заавал шалгах зэргээр нүсэр шалгалт явуулж байна.

Татварын буцаан олголт

Засгийн газар болон судалгааны байгууллагуудын тоо мэдээнээс харахад НӨАТ нь татварын орлогын хэдэн хувийг бүрдүүлж байгаа нь тодорхойгүй байна. Нэг мэдээнд НӨАТ нь татварын орлогын 12 хувийг бүрдүүлдэг гэсэн байхад нөгөөд нь 30 хувь гэж гарчээ. Эндээс НӨАТ-ын орлого юунаас бүрдэж байна вэ гэдэг асуулт гарч ирж байна. Иргэд аж ахуйн нэгжийн төлөхөөр тооцсон НӨАТ-аас улсаас буцааж авах НӨАТ-ыг хассан цэвэр дүнгээс бүрдэж байна уу эсвэл зөвхөн улсад төлөхөөр тооцсон НӨАТ-ын дүнгээр орлогыг тодорхойлж харин улсаас буцаан олговол зохих НӨАТ-ыг тусад нь тайлагнаж байна уу. Гаалийн байгууллагын хурааж буй НӨАТ-ыг НӨАТ-ын орлогод оруулж байна уу эсвэл гаалийн татвараар тооцож байна уу.

НӨАТ-ын орлого нь улсад тушаасан дүнгээр хэмжигдэж харин буцаан олголтыг тусдаа улсын төсвийн зарлага байдлаар ойлгож, тайлагнах нь онолын хувьд буруу юм. Татварын буцаан олголт нь НӨАТ-ын орлогыг тодорхойлоход хасагдаж тооцогдох ёстой үзүүлэлт юм. НӨАТ-ын орлого гэдэг тоо хэмжээг юунаас бүрдэж байгааг сайтар судалж шинжлэх нь өнөөдөр үүсч буй НӨАТ-ыг тойрсон асуудлыг цэгцэлж шийдэхэд нэн чухал билээ.

НӨАТ-ын системийн тогтолцоо нь худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг аж ахуйн нэгжүүдэд тэдгээрийн борлуулалтын НӨАТ-аас хасалт хийх аргаар буцааж олгодог систем. Аж ахуйн нэгж нь тухайн хугацаанд бага худалдан авалт хийсэн бол цэвэр дүнгээрээ улсад төлөх НӨАТ-ын өртэй гарч байхад нөгөө нэг аж ахуйн нэгж нь тухайн хугацаанд их хэмжээний худалдан авалт хийж, улсаас НӨАТ буцааж авахаар гарч болох юм. Тухайлбал экспортлогч компаниудын

хувьд экспортын борлуулалтын НӨАТ тэг хувьтай тул экспортлогч компаниуд худалдан авалтадаа төлсөн НӨАТ-ын дүнгээр улсаас НӨАТ буцаан авахаар гардаг. Бизнес хоорондын борлуулалтын үнэд НӨАТ-ын нөлөөлөл орж үнийг гажуудуулахгүй байх, бизнес эрхлэгчийн үнийн болон бизнесийн шийдвэрт нөлөөлөхгүй байхын тулд үйлдвэрлэгч, борлуулагч аж ахуйн нэгжүүдийн хооронд хийгдэж буй худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг хасуулах, буцаан авах ёстой ба харин эцсийн борлуулалтад уг татварыг ногдуулж эцсийн хэрэглэгчид төлдөг.

Дүгнэлт ба хуулийн хэрэгжилтийг сайжруулах нь

Хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй дээрх доголдууд, НӨАТ-ын хуулийг дагаж мөрдөхөд шаардагдах цаг хугацаа, гарах өртөг зардал, чирэгдэл ихтэй байнгын шалгалтууд зэрэг нь хуулинд бурууг тохоож, НӨАТ-ын хуулийг манай улсад тохиромжгүй мэтээр хэлэлцэж ярилцахад хүргэж байна.

- **Бизнес хоорондын борлуулалтын үнэд НӨАТ-ын нөлөөлөл орж үнийг гажуудуулахгүй байх, бизнес эрхлэгчийн үнийн болон бизнесийн шийдвэрт нөлөөлөхгүй байхын тулд үйлдвэрлэгч, борлуулагч аж ахуйн нэгжүүдийн хооронд хийгдэж буй худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг хуулийн дагуу хасуулах, үүнийг гажуудуулахгүй байхын тулд хасуулах тухай тодорхой заалтуудыг хуулинд нэмж оруулах ба хэрэгжүүлэх**
- **Жил бүр улам уртсаж байгаа НӨАТ-өөс чөлөөлөгдөх бүтээгдэхүүн болон үйлчилгээг уртсгахын оронд үр дүнтэй шуурхай илүү төлөлтийг буцаан олгодог механизмыг бий болгох.**
- **Уул уурхайн эцсийн бүтээгдэхүүнээс бусад бүх ашигт малтмалыг НӨАТ-өөс чөлөөлөх тухай заалт орсоноор уул уурхайн бүтээгдэхүүн боловсруулах ажил хэр өрнөсөн гэдгийг судалж, энэ заалтын бодит үр дүнг судалж, шийдвэрлэх**

- **НӨАТ-өөр бүртгүүлэх борлуулалтын орлогод үндэслэсэн босгыг одоогийн 10 сая төгрөгөөс нэмэгдүүлэх ёстой ба сайн дурын үндсэн дээр тодорхой шалгуурыг хангасан бүтээн байгуулалтын шатандаа маш их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг төсөл хөтөлбөрүүдийг НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх боломжийг олгох**
- **Татварын хяналт шалгалтын арга аргачлалыг сайжруулж, НӨАТ-ын өөрөө өөрийгөө хянадаг механизмыг ажиллуулж, түүнд суурилсан шуурхай шалгалтын аргад суралцах, хэрэгжүүлэх**

Эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан татварын зөвлөмж удирдамжуудыг манай улс хэрэглэсээр ирсэн. Тус байгууллагаас НӨАТ-ыг хэрэгжүүлэх талаар өнгөрсөн дөрөвдүгээр сарын сүүлээр удирдамж гаргасан бөгөөд уг удирдамжаар хил дамнанас үйлчилгээ болон аж ахуйн нэгж хоорондын хийж буй ажил үйлчилгээнд ногдуулах НӨАТ-ын татварыг зохицуулахдаа баримтлах зарчмыг боловсруулан баталсан. НӨАТ нь эцсийн хэрэглэгчдэд ногдуулдаг хэрэглээний татвар гэдгийг үндэс болгон эдгээр зарчмуудыг баталжээ. НӨАТ-ын хуулийг хэрэгжилтийг сайжруулах, арга аргачлалыг сайжруулахдаа энэхүү удирдамжаар заасан зарчмуудыг судалж үзэх хэрэгтэй.

Сайтар загварчилж хуульчилсан НӨАТ нь хамгийн их татварын орлогыг хамгийн тогтвортойгоор бүрдүүлдэг төсвийн орлогын эх үүсвэр гэдгийг олон улс даяар зөвшөөрч үүний улмаас НӨАТ-ын системийг хэрэгжүүлэх улс орон улам олон болсоор байна. Гэвч сайтар загварчлагдсан хуулийн хэрэгжилт нь доголдвоос бизнес хөрөнгө оруулалтын орчинд татварын дарамт бий болгож, хэрэглээний татвар гэдэг зориулалтаа алдаж улмаар татварыг ногдуулж төсөвт төвлөрүүлэх гол хүчин болох бизнесийнхэн энэ хуулийг төвөгшөөх, эсэргүүцэх улмаар хууль нь хэрэгжихгүй унах эрсдэл үүсдэгийг тэмдэглэж байна. ■

ЗАХ ЗЭЭЛ

ЦЕМЕНТИЙН ҮЙЛДВЭРИЙН ЭРИН

Б.БАЯРТОГТОХ

Манай улсын цементийн хэрэгцээ жил ирэх тусам өсөн нэмэгдэж энэ онд хоёр сая тонн-оос илүү гаргахаар байгаа. Тэгвэл үүнийхээ 60 гаруй хувийг Хятадаас худалдан авч, чамгүй валютыг өнгөрсөн хугацаанд гадагш урсгажээ. Тухайлбал, 2007-2012 онд ойролцоогоор 500 сая ам.долларыг цемент авахад зарцуулсан байна. Шинэ мянганд Монголын цементийн хэрэглээ 10 дахин өссөн байдаг. Өнгөрсөн жилд л гэхэд манайх 1.8 сая тонн цемент хэрэглэсэн бөгөөд үүний 65 хувийг импортоор авчээ.

XX зууны Монгол Улсын мега төслүүдийн нэг нь Хөтөлийн цемент шохойн үйлдвэр. Тус үйлдвэр бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу “Бэйзмент” компанийн мэдэлд очсон. Тэгвэл өнөөдөр тус үйлдвэр төрөл арилжиж, нойтон аргаас хуурай технологийн аргад шилжсэн. Ингэснээр жилд 1-1.5 сая тонн цемент үйлдвэрлэхээр хүчин чадлаа нэмлээ. Үр дүнд нь цементийн үнэ буурч,

нийлүүлэлт нэмэгдэж, дотоодын зах зээлийн 60 хувийг дангаар хангах тэнхээтэй боллоо.

Цементийн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх томоохон бүтээн байгуулалтууд цааш үргэлжилнэ. Үндэсний компаниудын төлөөлөл болох “Монполимет”, МАК тус бүр нэг сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай хоёр үйлдвэр барьж байгаа. Эдгээр үйлдвэр 100 хувь импортыг орлоод зогсохгүй бүтээгдэхүүнээ экспортод гаргах шаардлагатай болж байгаа юм.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа жигдэрч, хүчин чадлаа 100 хувь ашиглахын цагт дотоодын цементийн зах зээлд цементийн илүүдэл үүсч мэдэх нь. Гэхдээ үндэсний хэмжээний нүсэр бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрүүд ар араасаа жагсч байгаа нь итгэл төрүүлнэ. Тэд хэрэгжээд эхэлснээр цементийг бараг л “ууна” гэсэн үг. Гэсэн ч дотоодын цементийн зах зээлд өрсөлдөөн улам ширүүсэх нь.

Төв аймгийн Сэргэлэн суманд Хятадын хөрөнгө оруулалтаар цементийн томоохон үйлдвэр тун удахгүй ашиглалтад орох гэж буй. Уг үйлдвэр жилдээ 1-2 сая тонн цемент үйлдвэрлэх бөгөөд энэ нь дотоодын үйлдвэрлэгчдэд сөргөөр нөлөөлөх бололтой. Хэдий бүтээн байгуулалт эрчимжих ч нийтдээ 4-5 сая тонн цементийг Монгол Улс “шингээж” чадахгүй. Экспортод нийлүүллээ гэхэд БНХАУ лавтай худалдан авахгүй.

Харин хойд хөршийн хил дагуух хот, сууринд нийлүүлэх боломжтойг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан хэлж байсан. Гэвч хойд хөршийн хил дагуух мужуудад нэг сая тонн ч цементийн эрэлт хэрэгцээ байхгүйг хэлэх хүн ч байна. Энэ тохиолдолд цементийн илүүдэл үүсч, үнэ навс унах эрсдэлтэй. Энэ нь үндэсний үйлдвэрлэгчдэд хүндхэн цохилт болж мэдэх юм.

Тухайлбал, Хөтөлийн цемент шохойн үйлдвэр багагүй өр, зээлийн хүчинд маш богино хугацаанд буюу жил зургаан сарын дотор шинэ үйлдвэр ►►



▶ сүндэрлэн боссон. Тус үйлдвэрийн захиалгаар үндэсний хөрөнгө оруулагч “Бэйзмент” компани 250 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төсөл хэрэгжүүлж байгаа. Одоогоор үйлдвэрийн өргөтгөлд 157 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаа дуусахад долоон жил бий бөгөөд энэ хугацаанд “Бэйзмент” хөрөнгө оруулалтаа нөхөх учиртай.

Дорноговь аймгийн Хөх цавын шохойн ордыг түшиглэн барьж буй МАК компанийн цементийн үйлдвэр 350 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар босно. Үйлдвэр зургаан жилийн дотор зардлаа нөхөх зорилготой. Тус үйлдвэр өдөрт 3000 тонн цемент бүтээгдэхүүн гаргах хүчин чадалтай. Үр ашгийн хувьд гэвэл үйлдвэр ашиглалтад орсноор 350 гаруй байнгын ажлын байр бий болох бөгөөд төсөвт жилд 16 тэрбум төгрөгийн орлого төвлөрөх аж. Үйлдвэр энэ онд багтан ашиглалтад орох юм.

Хөх цавын цементийн үйлдвэр хуурай аргын технологитой. Үйлдвэрийн барилгын ажил 70, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 100, тоног төхөөрөмжийн татан авалт 93 хувьтай яваа. Зураг төсөл, үндсэн техник тоног төхөөрөмжийг нь цемент үйлдвэрлэлийн технологийг тодорхойлогч, энэ чиглэлээр 130 гаруй жилийн туршлагатай Дани улсын “FLSmidth” компани нийлүүлжээ.

Цементийн бас нэг шинэ үйлдвэр бол “Гермес хахиур”. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Билүүтийн-2 шохойн чулууны ордыг түшиглэсэн “Гермес хахиур” компанийн барьж буй үйлдвэр хүчин чадлын хувьд харьцангуй бага. Жилд 240 мянган цемент үйлдвэрлэх юм байна. Үйлдвэрийн барилгын ажил 2011 онд эхэлсэн бөгөөд ирэх оны наймдугаар сар гэхэд бүрэн ашиглалтад орох аж. Ингэснээр орон нутгийн барилгын материалын хэрэгцээг хангах юм.

Харин 170 жил ашиглах шохойн чулууны нөөцтэй Сэнж худаг ордыг түшиглэн барьж буй цементийн үйлдвэрийг “Монполимет” группын охин компани “Сэнж-Сант” барьж

байгаа. Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт байрлах тус үйлдвэр мөн адил хуурай технологийн аргаар жилд нэг сая тонн цемент үйлдвэрлэнэ. Цементийн үйлдвэр ирэх онд ашиглалтад орох бөгөөд зардлаа 4-5 жилийн дотор нөхөх бололцоотой аж.

Дэлхийн ихэнх улс хуурай аргын технологиор цемент үйлдвэрлэж байна. Хуурай арга нь нойтон аргаас 4-5 дахин бага ус ашигладаг, хоёр дахин бага түлш зарцуулдаг, эрчим хүчний хэрэглээг 30 хувь хэмнэдэг, тоосжилт багатай, хаягдлаа дахин ашиглах боломжтой эко технологи.

Манай улсын цементийн жилийн хэрэглээ ирэх жилүүдэд 3.5 сая тоннд хүрнэ гэсэн өөдрөг судалгаа бий.

Өнгөрсөн оны байдлаар дотоодын зах зээлд нийт 1.8 сая орчим тонн цемент хэрэглэснээс Хөтөлийн “Цемент шохой” хувьцаат компани, “Эрэл цемент”, “Налгар түшиг”, “Централ Ашиан цемент” нийлээд 500 гаруй мянган тонн-ыг үйлдвэрлэсэн байдаг. Энэ нь нийт хэрэглээний 40 хүрэхгүй хувийг дотоодын үйлдвэрлэгчид хангаж байна гэсэн үг.

Харин дээр өгүүлсэн цементийн үйлдвэрүүд үндэсний хэрэгцээг 100 хувь хангах юм. Гэвч тэдэнд шинэ өрсөлдөгч гараад ирсэн. Энэ нь Хятадын хөрөнгө оруулалттай цементийн үйлдвэр болж байна. Иймд цементийн хомсдол гэгчийг улсаараа мартаж ч илүүдэл үүсэх нөхцөл байдал руу орж мэдэх нь ээ. ■

МӨНГӨНИЙ БОДЛОГО

БОДЛОГЫН ХҮҮ ЭЦСИЙН СОНГОЛТ УУ

Б.БАЯР

Бодлогын хүүг нэмэх нь бизнесийн Борчинд төдийгүй макро эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлж ирсэн. Тэгвэл хатуу мөнгөний бодлого бизнесийн орчинд халтай юу гэсэн асуудал эндээс урган гарч байна. Монголбанкны Ерөнхийлөгчийн дэргэдэх Мөнгөний бодлогын зөвлөл яг энэ асуудлаар хоёр удаа хуралдсан. Гэхдээ тэд бодлогыг хүүг яаран өсгөсөнгүй. Засгийн газраас хэрэгжүүлж буй Эдийн засгийг эрчимжүүлэх хөтөлбөрийн үр дүнг хүлээхээр болсноо мэдэгдсэн. Хэдий хүүг өсгөх эцсийн шийдвэр хараахан гаргаагүй ч аргагүй тохиолдолд авах арга хэмжээ гээд орхисон байж болох талтай.

Тэгвэл бодит байдал дээр валютын ханшийн хямралаас гарах нэг гарц

нь бодлогын хүүг өсгөх болчихоод байна. Үүнийг Монголбанк төдийгүй Засгийн газар хараахан хүсэхгүй нь мэдээж. Гэвч валютын ханшийг суллах гэсэн нийгмийн захиалга бодлогын хүүг өсгөж, төгрөгийн нийлүүлэлтийг татаж авах шаардлагыг тэдэнд тулгах боллоо. Хэрэв Мөнгөний бодлогын зөвлөл бодлогын хүүгээ нэмлээ гэхэд ирэх намраас түүний нөлөө бидний амьдралд бодитоор мэдрэгдэнэ.

Үр дүнд нь ханшийн дарамт багасч, инфляци нэг оронтой тоо руу орж ирэх магадлал нэмэгдэнэ. Нөгөө талдаа эдийн засаг агшиж, мөнгөний эргэлт удааширч, арилжааны банкууд зээлээ бараг л зогсооход хүрнэ. Системийн нөлөө бүхий томоохон банкууд зээлээ нам гацаахгүй ч ийм нөхцөлд хүүгээ чангалдаг. Ингэснээр 100 хувийн баталгаатай, боломжийн хүүтэй ▶

► Төвбанкны үнэт цаас, Засгийн газрын бондод түлхүү мөнгө оруулах сонирхол давамгайлж, зах зээл валютын хомсдлоос мөнгөний хомсдолд шидэгдэх сул талтай.

Бизнесийн идэвхжил саарч, худалдаа үйлчилгээний өртөг нэмэгдэж, худалдан авалт энэ хэрээр муудах аюултай. Үүний уршгаар 20 гаруй мянган хүний ажлын байр үгүй болох эрсдэлтэй. Баялаг бүтээгчдэд хүрдэг бизнесийн зээл Монголбанкны үнэт цаасанд хөрвөх магадлалтай. МУИС-ийн багш, доктор, профессор Б.Эрдэнэбат “Хэрэв бодлогын хүүг өсгөвөл зээлийн хүү өснө” хэмээсэн. Тэрбээр “Зээлийн хүү өсөх нь эргээд иргэдэд хүнд ачаа болж шударгаар бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд сөрөг үр дагавартай” гэв.

Харин “Найман шарга” валютын захад 1830 төгрөгт хүрээд буй ам.долларын ханш бага зэрэг доошилж, хүсэл биелэлээ олох баяртай мэдээг бид эндээс сонсох болно. Энэ нь механик аргаар ханшийг буулгаж буй хэрэг. Гэхдээ маш том “золиос” гаргаж сая ханш тогтворжино гэдгийг мартаж болохгүй. Өөрөөр хэлбэл, ажилтай, орлоготой хүн цөөрч байж эдийн засаг дахь валютын савлагаа намжих юм. Түүнээс гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж, экспортын орлого сэргээд ханш тэнцвэржиж байгаа үзэгдэл энэ огтоос биш аж.

2008-2009 оны хямралаар 70 орчим мянган ажлын байр “устаж”, ажилгүйдлийн түвшин урьд жилүүдийнхээс өндөр гарсан байдаг. Энэ үед Монголбанк бодлогын хүүгээ 14 хувь хүртэл нэмэгдүүлж, хямралаас хөнгөн гарах гэж чардагж байсныг уншигч та санах биз ээ. Энэ үед валютын ханшаа барих гэж Монголбанк валютын нөөцөө “гөвсөн”. Үүнтэй жишиж үзэхэд 20 мянган хүн ажилгүй болно гэдэг нэг талаас хүлээн зөвшөөрч болмоор тоо ч байж мэдэх юм. Гэвч энэ бол хүсэх тоо биш. Нэг ч гэсэн хүний ажлын байрыг хадгалж үлдэхийн тулд нийтээрээ ханшийн өсөлтөөр торгуулах нь илүү боломжийн хувилбар ч байж магадгүй хэмээн Төвбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал тайлбарласан удаатай. Тэрбээр “Хэрэв валютын ханшийн огцом өсөлтөд эдийн засгийн хүндрэлээ шингээгээд явлаа гэхэд



одоо байгаа ажлын байраа хадгалж үлдэх боломжтой” гэсэн.

Монголын эдийн засгийн “хөдөлгүүр” нь хувийн хэвшлийнхэн байдаг. Тэд арилжааны банкны зээлээр үйл ажиллагаагаа өргөжүүлж, богино хугацаатай хөрөнгө оруулалтаар “амь зогоож” ирсэн. Баялаг бүтээгчид өнөөдөр эдийн засгийн хямралд өртөж, ханшийн эрсдэлээс болж зарим нь “шатаж” байгаа. Монголын эдийн засаг нийтдээ хямралтай нүүр тулж буй. Ийм эгзэгтэй мөчид Монголбанкны бодлогын хүүг нэмэгдүүлэх нь бизнесийн орчинд төдийгүй эдийн засагт гацаа үүсгэж мэдэх. Тэр тусмаа үндэсний үйлдвэрлэгчдийн хувьд бодлогын хүүг нэмэгдүүлэх нь мөнгөгүйн зовлонд унахын дохио.

Монголбанк валютын нөөцийнхөө 50 хувийг ханшийг тогтворжуулахаар захад нийлүүлчихээд байна. Ийм нөхцөлд бодлогын хүүг чангаллаа гэхэд эдийн засаг бүр ч доройтох эрсдэлтэй гэх. Тиймээс ажлын байраа авч үлдэхийн тулд импортын хэрэглээгээ хумихын сацуу ханшийн өсөлтөөр торгуулах сонголт бидэнд байгаа. Үүнтэй санал нийлэхгүй гэвэл бодлогын хүүгээ чангалж, ажлын байраа “гээх” л болоод байна. Хэрэв ханш хамгаас чухал гэж үзвэл энэ нь нэг талаар зөвдөх ч өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн эдийн засгийн тэлэх бодлоготой

зөрчилдөх юм. Өөрөөр хэлбэл, бүтээсэн бүхнээ ирэх өдрүүдэд нураана гэсэн үг. Тэр тусмаа дундаж давхаргаа бэхжүүлэхээр зорьсон төрийн мөнгөний бодлогын хувьд буланд шахуулсан сорилт болох юм. Тиймээс Засгийн газарт Монголбанкны бодлогын хүүгээр эдийн засгийг засах гэж оролдох сонирхол лавтай үгүй биз ээ. Тэд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ Оюутолгойн далд уурхайн санхүүжилтэд ихээхэн найдлага тавьсаар буй.

Ажлын байраа авч үлдэхийн тулд одоогийн бодлогоор замнах шалтгаан байгааг Н.Золжаргал нэгэнтээ учирлаж байсан. Энэ нь эдийн засгийн тэлсэн мөнгөний бодлогыг цааш хэвээр хадгалах хувилбар. Харин уг сонголтоос татгалзаж, валютын ханшийн өсөлтийг сааруулахын тулд мөнгөний бодлогын хүүг чангаллаа гэхэд эдийн засаг царцаж, байдал бүр ч дордох эрсдэлтэйг Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн гүйцэтгэх захирал Б.Лакшми хэллээ.

Инфляци болон зээлийн хүүг бууруулах үндсэн түлхүүр бол бодлогын хүүг бууруулах асуудал гэж эдийн засагчид тодорхойлдог. Бизнес эрхлэгчид зээлийн хүү өндөр байгаад шүүмжлэлтэй хандаж ирсэн. Тэд мөнгөний бодлогын хүүг бууруулах шаардлагыг Монголбанкинд илгээсээр өнөөг хүрсэн. Гэтэл мөнгөний бодлогын хүү эсрэг зүгт явах гээд байгаа нь энэ.

Бодлогын хүүгээс зээлийн хүүгийн түвшин шууд хамаардаг. Өөрөөр хэлбэл, бодлогын хүү өндөр байх нь зээлийн хүү өндөр байх нөхцөл болдог аж. Судлаач Б.Оюунбилэгт “Инфляци таригч-Монголбанк” өгүүлэлдээ “Мөнгөний бодлого өөрөө шууд ажлын байр нэмэгдүүлэхгүй, шууд хөрөнгө оруулалт болж үйлдвэрлэлийг сэргээхгүй. Харин үйлдвэрлэл хөгжих, ажлын байр нэмэгдэх суурь нөхцлийг нь бүрдүүлэгч анхдагч хүчин зүйл буюу эдийн засгийг хөгжүүлэх үндсэн хөшүүрэг” хэмээн дурджээ. Эндээс үзэхэд валютын ханшийг бууруулахын тулд бодлогын хүүгээ өсгөх нь тийм ч сайн сонголт биш бололтой. ■

ДЭЛХИЙН АВАРГЫГ ИЛҮҮ УХААЛАГ ТЕЛЕВИЗОРООР



32 инчийн ТВ бэлгэнд


УХААЛАГ ТЕЛЕВИЗОР худалдан авсан хэрэглэгч бүрт
SAMSUNG, SHARP брэндийн 2014 оны шинэ загварын
LED ТВ бэлэглэнэ

2014.06.11-07.15


ТООН МЭДЭЭ

2014 оны тавдугаар сарын 31-ний байдлаар Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянгол, Налайх дүүрэгт нийт 228 барилгын төслийн 40285 айлын шинэ орон сууц борлуулагдаж байна. Эдгээрийн 196 төсөл нь 39,296 айлын энгийн орон сууц, 32 төсөл нь 989 айлын хаусны зориулалттай сууц аж.


Орон сууцны төслүүд, үнийн интервалаар



Орон сууцны төслүүд, үнийн интервалаар



Орон сууцны 1м²-ын дундаж үнэ, дүүргээр



Дундаж үнийн өсөлт, дүүргээр (%)



Хуучин орон сууцны 1м²-ын дундаж үнэ(сая.төг), дүүргээр

	Баянгол дүүрэг			Сүхбаатар дүүрэг			
	1 өрөө	2 өрөө	3 өрөө	1 өрөө	2 өрөө	3 өрөө	
3-р хороолол	2.64	2.10	1.94	11-хороолол	1.91	2.39	2.08
4-р хороолол	2.27	2.16	2.10	7-р хороолол	2.50	2.16	1.95
10-р хороолол	2.11	1.95	1.81	5-р хороолол	2.81	2.78	2.64
Төмөр зам	2.59	2.18	2.17	220-н мянгат	2.50	2.69	2.80
6-р бичил хороолол	2.45	2.12	1.81	50-н мянгат	2.69	2.32	3.50

Орон сууцны төслүүдийн үнийн судалгаа, дүүрэг болон үнийн интервалын нэгтгэлээр (мян. төгрөгөөр)

Үнийн интервал	1800-аас доош		1801-2800		2801-ээс дээш		Нийт	
	Төслийн тоо	Дундаж үнэ	Төслийн тоо	Дундаж үнэ	Төслийн тоо	Дундаж үнэ	Төслийн тоо	Үнэ
БГД	0	0.0	20	2179.0	0	0.0	20	2 111.8
БЗД	14	1 589.7	52	2 275.7	12	3 547.078	78	2 401.3
НД	6	1 346.7	0	0.0	0	0.0	6	1 227.6
СБД	3	1 352.8	12	2 236.3	6	4 482.3	21	2 669.6
СХД	18	1 598.5	11	2 028.5	0	0.0	29	1 719.1
ХУД	5	1 700.0	31	2 335.3	33	3 902.0	69	2 879.2
ЧД	2	1 325.0	3	2 300.0	0	0.0	5	2 305.7
УБ	48	1 548.3	129	2 250.9	51	3 886.7	228	2 357.8

Нийт орон сууц ашиглалтад орох хугацаагаар

	Төслийн тоо	Айлын тоо	Дундаж үнэ (мян.төг)
Ашиглалтад орсон	88	10 242	2 419.0
2014-Q2	42	9 831	2 152.7
2014-Q3	25	3 338	2 140.6
2014-Q4	43	8 845	2 348.4
2015-Q1	18	5 315	2 491.6
2015-Q2	10	2 240	2 976.2
2015-Q3	2	474	2 571.9
Нийт	228	40 285	2 357.8

Зэрэглэл тус бүр, айлын тоогоор

	Төслийн тоо	Айлын тоо	Дундаж үнэ (мян.төг)	Нийт борлуулалтын орлого
Стандарт	63	10 593	1 711.5	711.0
Стандарт сайн	113	22 893	2 276.9	3 410.8
Тансаг	52	6 799	3 608.5	3 504.2
Улаанбаатар	228	40 285	2 357.8	7 626.1

Хуучин орон сууцны нийт үнэ (сая.төг), дүүргээр

	1 өрөө	2 өрөө	3 өрөө		1 өрөө	2 өрөө	3 өрөө
	Баянгол дүүрэг				Сүхбаатар дүүрэг		
3-р хороолол	86.87	108.00	128.33	11-хороолол	82.50	119.65	155.20
4-р хороолол	65.83	109.10	135.31	7-р хороолол	70.00	110.00	130.00
10-р хороолол	67.00	90.50	116.00	5-р хороолол	87.00	148.80	216.30
Төмөр зам	77.50	108.20	128.90	220-н мянгат	80.00	134.50	201.00
6-р бичил хороолол	76.00	103.70	127.00	50-н мянгат	80.70	111.70	138.00
Дундаж	74.64	103.9	127.10	Дундаж	80.04	124.95	168.10
	Чингэлтэй дүүрэг				Хан-уул дүүрэг		
Бага тойруу	80.00	130.00	150.00	19-р хороолол	69.00	110.00	130.00
40 мянгат	87.30	115.00	150.00	120 мянгат	80.00	137.80	197.80
6-р хороолол	73.40	118.50	148.30	Нисэх	53.15	70.00	90.55
Дундаж	80.23	121.16	149.43	Дундаж	67.38	105.93	139.45
	Сонгинохайрхан дүүрэг				Баянзүрх дүүрэг		
1-р хороолол	80.00	94.50	141.00	15-р хороолол	67.60	113.20	137.20
21-р хороолол	74.80	80.00	112.90	13-р хороолол	71.00	126.10	185.20
5 шар	52.25	61.75	91.60	16-р хороолол	70.50	86.25	117.50
ХМК	55.00	74.00	90.00	12-р хороолол	85	115.00	226.30
Дундаж	65.51	77.56	108.87	Дундаж	73.52	110.13	166.55

Эх сурвалж: Мастер Пропертис

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ

РОБЕРТ ФРИЙДЛАНД БА ӨӨДРӨГ ҮЗЭЛТЭН

Б.БАЯРТОГТОХ

Роберт Фрийдланд “Mongolia Business Summit-2014”-ийн гол зочин. Түүний нэр монголчуудад дэндүү дотно. Хэвлийдээ түмэн эрдэнэс нуусан Монголын өргөн говийг дэлхийд таниулсан түүний талаар манай хэвлэл мэдээллийнхэн нэг их бичээд байдаггүй. Харин энэ удаа манай сэтгүүл Фрийдландын тухай бичихээр шийдлээ. Яагаад гэвэл тэрбээр Монголд гадаадын хөрөнгө оруулалт татарч, уул уурхайн хөгжил хүлээлтийн байдалтай болсон үед зочилж байна. Роберт Фрийдландын хөдөлгөөнийг дэлхий ажиж суугаа. Магадгүй хөрөнгө оруулагчдыг хөдөлгөөнд оруулах ч юм бил үү. Өнгөрсөн жил тэрбээр Африкийн хөрөнгө оруулагчдын томоохон хуралд уригдан зочилсноор араасаа олон хөрөнгө оруулагч дагуулсан байсан. Тийм болохоор түүний бизнесийн болон хувь хүнийх нь онцлогийн талаар өгүүлье.

Роберт Фрийдланд суусан газраасаа шороо атгадаг нэгэн. Тэр оюутан ахуй цагаасаа л бизнес сэтгэлгээтэй, гүйлгээ ухаантай гэдгээ бусдад харуулж, зарим нэгийг нь алмайруулдаг байжээ. Стив Жобсын амьдралдаа шүтэн биширсэн цөөн хүний нэг нь Фрийдланд. Түүний эцэг нь Австри-Швейцарь гаралтай Чикагогийн нэр хүндтэй архитекторч.

Фрийдланд 1950 онд Чикагод төрж Бостонд өссөн. Тэр Ридийн их сургуулийн Оюутны зөвлөлийн ерөнхийлөгчөөр сонгогдож байсан адтай залуу. Өмнө нь Хүмүүнлэгийн ухааны Боудойний их сургуульд сурч байсан. Түүнийг туйлын өвөрмөц, өөрийнхөө үзэл бодлыг хамгаалж мэддэг. Мөн байнгын хөдөлгөөнтэй, өөртөө итгэлтэй гэдэг. Үүнээс гадна Роберт хүнийг өөртөө татаж чаддаг, жинхэнэ наймаачин хүн. Тэр хүмүүсийг хялбархан удирдаж, эрч хүчээр цэнэглэж чаддаг “хүний менежер”.

Дэлхийд нэртэй алт олборлогч, уул уурхайн корпорацийн эзэн болсон Фрийдланд Монголын Оюутолгойг дэлхийд зарласан. Үүний үр дүнд Монголын эдийн засаг асар богино хугацаанд хоёр дахин тэлж, ДНБ жилийн дотор 17.5 хувиар өссөн байдаг. Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалт эрс нэмэгдэж, Монгол Улс 2011 онд бага орлоготой орноос дундаж орлоготой орны тоонд шилжсэн.

Буурай хөгжилтэй Монголын эдийн засагт “Оюутолгой” төсөл хэрэгжсэн нь урьд өмнө байгаагүй хөрөнгө оруулалтын тэсрэлт байлаа. Өөрөөр хэлбэл, их мөнгөний



урсгал Монголын эдийн засагт цутган орж ирсэн юм. Фрийдландыг олонх нь Боб гэж дууддаг. Америкийн “Үндэсний шуудан” сонины сэтгүүлч Диана Францис /Dian-Francis/ түүнд таван жилийн дотор 45 оронд бизнесийн үйл ажиллагаа явуулсан учир “Хэрмэл эрэлчин” хэмээх алдар хайрлажээ. Фрийдланд 1980-аад оны үед Ванкуверт ирж уул уурхайн бизнест хөл тавьж азын эрэлд мордохоос өмнө “моддоо барих” шахтлаа ядарч явсан үе бас түүнд бий.

Фрийдланд Орегоны хаягдсан алтны уурхайг сэргээн хөгжүүлж Ванкуверийн хөрөнгийн бирж дээр худалдаж саятан болсон. Энэ бол түүний өсөж өндийсэн амьдралын давалгааны нэг. Тэрбээр Америк, Канад, Сингапур гэсэн ▶

▶ гурван улсын иргэншилтэй. Фрийдландын өөрийнх нь ярьснаар “1987 онд хувь заяа намайг Бони Пикен рүү явж 6.6 сая ам.долларын үнэтэй Нью Маунтын уурхайн төлөөх ширүүн тэмцэлд оролцоход хүргэсэн юм.

Тэр ажиллагаа Бунигийн уул уурхайн анхны бизнес байсан бөгөөд тэр надад бидний олсон 400 сая ам.долларын ашгийн 10 хувийг өгч түүгээр нь би уурхайн өөрийн эзэмшлээ худалдаж авсан” хэмээсэн. Энэ нь Фрийдландын хувьд Өмнөд Африкийн зах зээлд нэвтрэх том алхам болсныг тэр үгүйсгэж байгаагүй.

Диана Францисийн бичсэнээр Боб уран үгтэй, ухаантай учраас бусдыг өөртөө татаж чаддаг, ялангуяа хөрөнгө оруулагчдын хувьд Роберт Фрийдланд бол брэнд аж. Түүний геологичид 1994 онд Нью Фаундлэндийн Войсын буланд аварга том никелийн орд илрүүлснээр энэ нь Бобыг жинхэнэ том гар болгосон гэдэг. Мөн Өмнөд Африкийн никелийн уурхайн төсөлд оролцсон. Энэ бүхэн түүний амьдралын ээлжит нэгэн давалгаа байжээ.

Фрийдланд “1997 онд Ашигт малтмалын тухай хуулийн Канад хувилбарыг Монгол Улс авч хэрэглэх болсноор лиценз эзэмших эрх баталгаажсан тэр үед Монголд очсон. Гарамжав надад Оюутолгойд өрөмдлөг хий. Тэгвэл алт олно гэж хэлсэн бид хэлснээр нь өрөмдсөн. Энэ бол үнэхээр онцгой. Энэ бол дэлхийн алт зэсийн шинэ нутаг. Энэ бол энгийн нэг уурхай биш, энгийн нэгэн ашигт малтмал агуулсан талбай ч биш. Энэ бол алт зэсийн муж. Хэрвээ энэ бүгдийн дараа намайг суут ухаантан гэвэл түүний нууц нь Гарамжав шиг хүмүүсийн үгэнд орсонд байгаа юм” гэж Дианад ярьжээ.

Роберт Фрийдландыг тойруу замаар Монголд ойртуулж өгсөн хүний нэг бол Жеймс Бейкер. Энэ хүн бол АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга байсан ноён Жеймс Бейкер юм. Тэрбээр Техасын нефтийн компани Nescor-ыг Монголд үйл ажиллагаа явуулж эхлэхэд нь тусалцаа үзүүлжээ. Тус компанийг Нийл Салсич гэдэг залуу удирдаж байсан бөгөөд хөрөнгө оруулагчдынх нь тоонд Жорж Буш, Роберт Фрийдланд нар багтдаг байжээ.

1998 онд Салсич онгоцны ослоор таалал төгссөнөөр Nescor-ын Зүүн баян дахь Цагаан элсэн дэх нефтийн хайгуулын ажил зогссон юм. Харин Роберт Фрийдландын Монголыг сонирхсон сонирхол хэвээр үлдсэн байна. Түүнд Монголын эрдэс баялгийн талаар танилцуулсан хүн бол Австралийн ВНР компанийн хайгуулын хэсгийг толгойлж байсан Хюго Даммет байжээ. Энэ хүн нь хожим Оюутолгойн Хюго Дамметийн ордыг нээсэн.

Ихээхэн хэмжээний санхүүгийн алдагдалд орсон ВНР компани хайгуулын тусгай зөвшөөрлийнхөө ихэнх хэсгийг зарах хүсэлтэй байсныг “Айвенхоу Майнз” ВНР-ээс Оюутолгойн лицензийг худалдан авчээ. Ингэж Роберт Фрийдланд Оюутолгойтой хувь заяагаа холбосон түүхтэй. “Дэлхийн хамгийн том зэсийн уурхай Гразберг Индонезийн өндөр уулсын дунд бусад томоохон зэсийн уурхайнуудын нэлээд нь Чилид Андын нуруунд байрладаг бол Оюутолгойн орд металаар цангасан Хятадын хаяанд байна. Тийм учраас бид гол зах зээлийнхээ хажууд нь байгаа гэсэн үг” гэж Роберт тайлбарласан байдаг.

Нийтлэлч Баабар “Барон Роберт” нийтлэлдээ “Роберт Фрийдланд гэгч бас л жаахан хөөргөндүү эр азаа сорихоор ирсэн, энэ бол факт. Тэрээр ВНР хэмээх дэлхийн хамгийн том компанийн хайгуул хийгээд юу ч ололгүй хаяад явчихсан Оюутолгой гэгч газрын хайгуулын эрхийг авч эрсдэл гарган тэрбум шахам доллар зарцуулсан, энэ бас факт. Хэрэв юу ч олохгүй бол тэгээд л тэр чигээрээ дампуурах байсан ч аз ивээж Монголын говиос дэлхийн хамгийн том зэсийн орд олсон, энэ бас факт. Фрийдландыг гэхээсээ монголчуудыг аз бүр ч илүүтэй гийсэн. Индонезийн төстэй ордыг олохын тулд геологичид дээгүүр нь 30 жил хайгуул хийсэн гэдэг. Ийм эрсдэлтэй алхмыг галзуудуу л хүн хийнэ. Оюутолгойг олоогүй бол, хэрэв Фрийдланд хүн үнэмшмээргүй зоригтой эрсдэл хийгээгүй бол - Монгол орон өнөөдөр хэний ч сонирхол татахгүй хаягдмал орон хэвээрээ үлдэх байсан. Энэ бас хөдөлгөөнгүй үнэн. XXI зууны шинэ Монгол босч ирэх гол учгийн нэгийг бүтээсэн хүний нэг бол Роберт мөн” хэмээн нийтлэлдээ онцолжээ.

Тэрбээр нийтлэлдээ “Зөвхөн 1990-2000 оны хооронд “төрийн гурван өндөрлөг” гэгчээс 200 гаруй удаа Монголд хөрөнгө оруулалт хийхийг албан ёсоор гуйж энд тэнд үг хэлсэн байдаг. Гэвч дэлхийн зах зээл гэгч тийм амар эд биш аж. ВНР, Anglogold, BP гээд аварга компаниуд орж ирэн жаал шиншилж үнэртэж үзсэнээ л эргээд гараад явчихна. Улс оронд мөнгө хэрэгтэй, зарж болох ганц юм нь ашигт малтмал, гэтэл тэрийг нь хүн тоодоггүй. Хууль гаргаж хөнгөлөлт үзүүлнэ гэж амлаад ч нэмэр байдаггүй” хэмээсэн.

Фрийдланд тэрбумтан болох гараа 1993 оноос эхтэй. Тухайн үед үүсгэн байгуулсан Даймонд Фиелд Ресорсе компанийн нээж илрүүлсэн Войзей Бэй орд нь дэлхийн хамгийн том никель, зэсийн ордод тооцогдож байжээ. Ингэснээр хувьцааны үнэ нь дөрвөн ам.доллараас 167 ам.долларт хүрч Фрийдландын хөрөнгийг ихээхэн нэмэгдүүлсэн гэдэг. Түүний жилийн нийт орлого 2.8 тэрбум ам.доллар. Forbes сэтгүүлээс түүнийг дэлхийн тэрбумтнуудын жагсаалтын 546-д оруулсан байдаг. Харин АНУ-ын тэрбумтнууд дунд 188-д бичигддэг байна.

Р.Фрийдланд алдартай. Гэвч тэр нууцлаг байж чаддаг нэгэн. Түүний нэр уул уурхайн салбарт домог. Ийм атлаа чухам хэн бэ гэдэг нь төдийлэн ил бус. Уул уурхайн магнат, тэрбумтан тэрбээр айлын том хүүхэд бөгөөд доороо хоёр дүүтэй. Түүний дүү Эрик Фрийдланд нь Канадын хамгийн хойд зүгт Бафийн аралд алмаазны хайгуул хийдэг “Peregrine Diamonds” компанийн гүйцэтгэх захирал.

Оюутолгой ордыг зах зээлийн эргэлтэд оруулж, Монголын эдийн засагт томоохон өөрчлөлт авчирсан Р.Фрийдланд бол өөдрөг үзэлтэй нэгэн. Түүнд дэлхийн хөрөнгө оруулагчид итгэдэг. Тиймээс Фрийдланд олон улсын зах зээлээс хөрөнгө босгож, төслүүдээ амжилттай удирдаж ирсэн. Тэр бол хөрөнгө оруулагчдыг “урхидаж” чадах онцгой авъяастай нэгэн. Хэрвээ Фрийдланд Оюутолгойг “тоогоогүй” бол манай эдийн засагт огцом эргэлт гарахгүй байсан. Монгол дэлхийн зэсийн томоохон тоглогч болохгүй байлаа. Тиймээс Р.Фрийдландад нэг удаа ч гэсэн баярлалаа гэж хэлье. ■



Л.БЯМБААГИЙН БУЛАН

ЭДИЙН ЗАСГИЙН УНАЛТЫН ҮЕИЙН БИЗНЕСИЙН СТРАТЕГИ

Эдийн засгийн уналт явагдаж буйг илтгэсэн статистик тоон үзүүлэлт илт байна. Харин эдгээр тооны цаадах учир шалтгааныг зөв тодорхойлох нь цаашид эдийн засгийн бодлогын хэмжээнд төдийгүй, бизнес эрхлэгчид ямар стратеги авч хэрэгжүүлэх ёстойг тогтооход чухал үүрэг гүйцэтгэнэ.

Уул уурхайн салбарын гацаа, мөн хуулийн орчин өөрчлөгдсөн нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг бууруулж улмаар валютын ханш дээр хүнд туссан. Үүний зэрэгцээ тодорхой хэмжээний албан бус секторын мөнгөний эргэлт саарсан, гадагшилсан ч байх магадлал өндөр байна. Ханшаас үүдэлтэй инфляци, зээлийн чанаргүйдэл нэмэгдэж байгаа үр дүн мөн ажиглагдаж байгаа юм. Төрийн оролцоо бизнесийг дэмжсэн бус, түрсэн байдалтай байгаа нь хувийн хэвшлийг идэвхижлийг сулруулж мөнгөний үржвэр, хөшүүрэг багасгахад нөлөөлсөн гэж дүгнэхэд хүргэж байна. Эдгээрийн хажуугаар тодорхойгүй байдал, төрийн шийдэмгий бус байдал нь ард иргэд, бизнесийн сөрөг хүлээлтийг дэвэргэж, уналтыг улам даамжрууллаа.

Бизнес ба эдийн засгийн мөчлөг: Ийм нөхцөл байдал бизнест хэрхэн тусч байна вэ? 2014 оны эхний улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 18.8 хувиар буурсан байна. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс 2014 оны эхний улиралд өмнөх оны мөн үеийнхээс 4.6 хувь, өмнөх сарынхаас 2.5 хувиар өсч, харин жилийн эцсийнхээс 5.3 хувиар буурчээ. Бүх төрлийн тээвэр эхний улиралд 10.2 хувиар өсч, харин зорчигчдын тоо 6 хувиар буурсан байна (ҮСХ). Бизнесийн идэвхижил, ашигт ажиллагаа үргэлжлүүлэн буурах чиг хандлагатай байна.

Онолын хувьд хямрал бөгөөд эдийн засгийн мөчлөгт өртөмтгий, өртдөггүй, мөн эсрэгээр тэлдэг салбарууд гэж байдаг.

Монголын хувьд салбаруудын 2012/2011 оны өөрчлөлт, мөн 2013/2012 жилийн өөрчлөлтийн хувийг харьцуулан харахад өсөлтийн хувь тээвэр, хоол хүнс, санхүү, даатгал, соёл үзвэр үйлчилгээ зэргийнх ихээр саарсан бол барилга, уул уурхайн олборлолт, усан хангамж, хог хаягдлын салбарын

Өртөмтгий салбар	Өртдөггүй салбар	Өсдөг салбар
Үл хөдлөх, барилга	Эрүүл мэндийн үйлчилгээ	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ
Аялал жуулчлал, тээвэр		Даатгал
Импортын худалдаа	Хүнс, хоолны худалдаа	Авто засвар үйлчилгээ
Үйлчилгээ		Хуулийн зөвлөх үйлчилгээ
Уул уурхай	Мэдээллийн технологи	
	Боловсрол	
Тансаг хэрэглээ		Архи, тамхи
	Нийтийн ахуйн үйлчилгээ ус цахилгаан гэх мэт	Банк бус санхүүгийн үйлчилгээ


өсөлтийн хувь нэмэгдсэн байна. Харин төдийлөн өөрчлөлт ороогүй салбарт боловсрол, эрүүл мэнд, цахилгаан хангамж зэрэг багтаж байна.

Уналтын үеийн бизнесийн стратеги: Уналтын үед хэмнэлтийн горимд шилжиж зардал танах, хүмүүсээ ажлаас халах зэрэг нь тэргүүн ээлжинд авах ёстой арга хэмжээ гэж бодогдох байх. Гэхдээ үүнд бас ухаалаг стратеги боловсруулж, хэрэгжүүлэх нь чухал. Нэгэнт халсан ажилтанг дараа нь нөхөж авах, сургах, зах зээлд эзлэх хувийг буцаан нэмэгдүүлэх, зогссон үйлдвэрийг сэргээх эсвэл алдсан харилцагчийг буцаан авчиргахад дараа нь илүү өндөр зардал гардагийг санах хэрэгтэй.

Стратегийн дараах хувилбаруудыг компаниуд авч хэрэгжүүлж сөрөг үр дагаварыг бууруулж болох юм.

- Үр ашгийг нэмэгдүүлэх: бизнесийн үйл явцад шинжилгээ хийж үргүй зардлыг хумих ▶

Салбаруудын өсөлт ба бууралт




Эх сурвалж: YCX

- Бүтээмжийг сайжруулах: хүмүүсийг ажлаас халах бус харин бүтээмжийг сайжруулж үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлэх
- Төлөвлөлтийг сайжруулж гэнэтийн байдлаас хамгаалах: тодорхойгүй байдал эрсдэлийг нэмэгдүүлдэг тул төлөвлөлтийг сайжруулж гэнэтийн зүйлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэрэгсэл ашиглах. Жишээ нь, даатгалын бүтээгдэхүүн, ханшийг түгжих бүтээгдэхүүн ашиглах
- Харилцагч, үйлчлүүлэгчийн зан төлөвийг гүнзгийрүүлэн судлах: компанийн бүтээгдэхүүний хэрэглэгчийн зан төлөв хямралын орчинд илүү сайн илэрдэг тул бүтээгдэхүүнийхээ үнэд мэдрэг байдал, борлуулалтын ямар стратеги илүү үр дүнтэй байгаа зэрэгт дүн шинжилгээ хийж авах
- Зах зээлийн дүн шинжилгээг сайжруулах: орчины, өрсөлдөгчийн, зах зээлийн судалгааг сайн хийж, илүү сайн ойлгох
- Бүтээгдэхүүнийг сайжруулах: борлуулалтыг

бууруулахгүйн тулд бүтээгдэхүүний сайжруулалт хийх замаар хэрэглэгчийн тоог хэвийн түвшинд барих



- Шинэ бизнесийн бэлтгэл ажил хийх: хямралын үед үйлдвэрлэлийн өртөг буурсан байдаг тул шинэ бүтээгдэхүүний туршилт хийх, эсвэл шинэ бизнесийн бэлтгэл, суурь ажлыг эхлүүлэхэд тохиромжтой байдаг.
- Зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх: өрсөлдөөнт зах зээлд хямралын үед бусад өрсөлдөгчид бизнесийн үйл ажиллагаагаа хумьж байхад эсрэгээр цар хүрээгээ тэлж авах нь зах зээлд эзлэх хувиа хурдан нэмэгдүүлэх боломж олгодог.

Уналт, хямралын үед гарах хөрөнгө оруулалтын боломж: Аливаа хөрөнгө оруулалтын стратеги нь хөрөнгө оруулалтын хэрэгслийг хямд үнэлгээгээр авч хожим нь үнэ хүргэж зарах байдлаар үнийн зөрүүнээс ашиг олох байдаг. Энэ нь эдийн засгийн мөчлөгтэй шууд холбоотой. Мөчлөг доошлоход хөрөнгө оруулалтын хамгийн сайн боломжууд гарч ирдэг. Монголын хөрөнгө оруулалтын боломжит активын өгөөжийг 2013 оны байдлаар харуулахад дараах дүр зураг ажиглагдаж байна.▶




Эх сурвалж: Мандал Ассет Менежмент


Харин 2014 оны тухайд хөрөнгө оруулалтын хэрэгсэл тус бүрээр авч үзье.



2014 оны долларын ханшийн таамаг, нэг ам.долларыг худалдан авах өртөг



Долларын бондын өгөөж



Дүгнэлт

- Эдийн засгийн уналт даамжирч хямрал болоход бизнесийн идэвхижил, ашигт ажиллагаа үргэлжлүүлэн буурах чиг хандлагатай байна.
- Уналтын үед тодорхой арга хэмжээ авч хямралаас сэргийлэх боломжтой.

- Бизнесүүд уналтын үед тохируулан онцлог стратеги боловсруулах замаар сөрөг үр дагаварыг бууруулж болно.
- Хөрөнгө оруулалтын хамгийн сайн боломжууд хямралын үеэр гардаг. ■

RECLAM6S.MN

Гарч хайснаас гараасаа хай...

Та reclam6s.mn сайтад бараа бүтээгдэхүүнээ реклам, видео зар сурталчилгаатай нь хамгийн хямд үнээр байршуулах боломжтой.

Таны худалдаа үйлчилгээг бид түгээнэ.



ВЭБ, МОБАЙЛ ВЭБ БОЛОН APPLICATION

3

ХОСОЛСОН ҮЙЛЧИЛГЭЭ



 **91116586, 96606586**

Бид хамтран ажиллахдаа таатай байх болно.



Б.ЭНХЦЭЦЭГ

Хяналтгүй хар тамхи, архи, эрх мэдэл, мөнгөний хэрэглээ мөн төрлөөс заяасан аливааг арилжаалах авьяас нь түүнийг луйварчин болгосон. Үнэт цаасны луйвар хийсэн хэргээр 2004-2006 онд 22 сар шоронд ял эдэлсэн “Уолл Стритийн Чоно” Жордан өнөөдөр борлуулалтын авьяасаа өөрийн болон бусдын амьдралыг чиглүүлэхэд ашиглаж байна.

Жордан 1990 оны үед өөрийн “Стратон Оакмонт” компаниар дамжуулан маш олон сая долларыг үнэт цаасны зах зээл дээрээс босгосон байдаг. Өдгөө 51 настай тэрбээр 2013 онд түүний амьдралаас сэдэвлэн бүтээсэн алдарт Мартин Скорсесс найруулагчийн “Уолл Стритийн Чоно” хэмээх киног тухайн үед өрнөсөн үйл явдлыг бодитоор дүрсэлсэн гэж хэлдэг. Тус киноны эхэнд Жордан Белфортын дүрийг бүтээсэн Леонардо Ди Каприо хэр их мөнгөтэй харьцаж байсан талаар “Би 26 нас хүрсэн жилээ 49 сая ам.долларын ашиг олсон нь миний уурыг үнэхээр их хүргэсэн. Учир нь тухайн жилийн долоо хоног бүр нэг сая ам.доллар олж байсан гэж нэрлэгдэхэд гуравхан сая ам.доллар надад дутсан юм” гэж хэлдэг. Хар багаасаа мөрөөдсөн баяжих хүслээсээ үүдэн оргилоос ангал руу унасан Жордан өнөөдөр өөрийгөө “Номхорсон Чоно” хэмээн тодорхойлж буй.

“Уолл Стритийн Чоно” энэ сард Монголд ирж, улс төр бизнесийнхэнд өөрийн гарамгай эзэмшсэн ятгах, ярих урлагаас хуваалцаж, Монгол хэрхэн өөрийгөө олон улсад зарж борлуулах талаар зөвлөсөн. Энэ үеэр тэрбээр манай сэтгүүлийн асуултад хариулах цаг бидэнд гаргасан юм.

ЗОЧИН

ОЛОН УЛСЫГ МОНГОЛООР “ЦЭНЭГЛЭ”

-Таныг юу амжилтад хүргэж, бас юу ангал руу унагасан бэ?

Миний амжилтын зүрх нь олон жил хэрэглэж ирсэн миний арга барил систем байсан. Найман настайгаасаа л олон төрлийн ажил хийж, мөнгөжих санаануудаа хэрэгжүүлж эхэлсэн. Харин 24 нас хүрээд хүмүүсийг сургах санаа төрж, өөрийн гэсэн сургалтын арга барилыг нээсэн гэж хэлж болно. Энэ нь “Шулуун шугам” гэж олонд танигдсан. Үүнийг сурахад гайхам хялбар атлаа өндөр үр нөлөөтэй техник бөгөөд энгийн нэгнийг дэлхийн хэмжээний борлуулагч болгодог. Энэ л үндсэндээ миний болон манай компанийн амжилтын ард байсан хүч. Гэвч бас миний уналт, ёс зүйгээ алдсан шалтгаан. Энэ бүх гамшиг ч гэж хэлж болохоор үйл явдлын үндсэн шалтгаан нь хэт хурдан өндөрт гарсанд оршдог.

Гэвч энэ олон жил өнгөрөхөд, амжилтад бас уналтад хүргэсэн шулуун шугамын системээ би бизнес маркетингаас эхлүүлээд удирдан чиглүүлэх гэх зэрэг

олон үйл ажиллагаанд ашиглах болсон. Ямар ч ажил, бизнес эхлүүлсэн дүрэм мэт үйлчилж, амжилтын ард зогсож байдаг тодорхой элементүүд байдаг. Энэ л миний амжилтын суурь байсаар ирсэн.

Тэдгээр өдрүүдэд бий болсон ажил амьдралын эндэгдэл нь агшин зуурын хэт их сэтгэл ханамж хөөрөл дээр суурилж байсан. Би дэндүү огцом хурдалсан, харин өнөөдрийн энэ өндөрлөгөөс бизнес гэж чухамдаа юу болохыг ухаарч, хурдаа хасч явна даа. Үнэ цэнэ гэгчийн мөн чанар, ач холбогдлыг тодорхойлж байна гэсэн үг. Үнэ цэнийг бусдад өгч чадахгүй аваас хэчнээн мундаг борлуулагч байсан ч нэгэн цагт эцсийн цэгтэйгээ тулгарна. Хэзээ ч байнгын энэ эрчээрээ зараад борлуулаад байна гэж байхгүй.

-Эргээд харахад таны хамгийн гүн харуусал юунд оршдог вэ?

Би хүмүүсийг сургах сургалтын тогтолцоог бодож олохдоо ▶

► компанийнхаа өсөлтийг сааруулалгүй огцом дээш цойлохыг зөвшөөрсөнд миний харамсал оршдог. Учир нь манай компанийн зах зээлээс түрүүлсэн хөгжил, өсөлтөд тохирсон тухайн үед салбарын зохицуулалт байгаагүй. Тиймээс зохицуулалт байхгүй ч бид үүнийг хуулинд байхгүй аргаар хийж, асар хурдан өссөн. Ингээд л замаас хазайж, өндөрт гарсны дүнд хяналтаас гараад явчихсан. Энэ бол миний хамгийн том алдаа.

-Хэрвээ цаг хугацааг эргүүлж болдог байсан бол Та юуг өөрчлөх вэ?

Би амжилтынхаа өсөлтийн хурдыг сааруулж, тогтворжуулах байсан. Мөн тэрхүү ёс суртахууны шугамыг давахгүй байх байлаа. Тэр олон хүнийг мөнгөө алдахад хүргэхгүй байх байсан.

-Бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй хүмүүсийн хувьд ёс зүйгүй үйл ажиллагаанд оролцож эхлэх цэг буюу зөв ба буруугийн хилийн дээс гэж байдаг уу?

-Би ёс журам, ёс зүйн шугам байдаг гэдэгт итгэдэг. Элэг бүтэн өсч, хүмүүжсэн хүмүүсийн дийлэнх нь үүнийг юу болохыг мэднэ. Тэд энэхүү шугамыг давах гэхдээ тийм нэг гэдэс өвдөх мэт таагүй мэдрэмжийг авдаг. Харин зарим хүмүүсийн энэхүү шугамыг давдаг шалтгаан нь өөрийгөө зөвтгөн хамгаалж, шалтагладаг байдал нь. Тэд энэхүү зураасыг давах тоолондоо өөртөө муугүй шалтаг бодон олж, өөрийгөө зөвтгөх бөгөөд зөвхөн энэ удаад л ингээд хийчихье гэдэг. Гэвч энэ бол урт хугацааны амжилтын жор биш. Тэрхүү хил хязгаарыг давсан л бол дагаад ёс суртахууны шугам байрнаасаа хөдөлдөг. Ингээд шугамыг давах тоолонд тухайн хүний ёс суртахууны шугам хэм хэмжээнээс холдсоор байдаг. Хэр хол явснаа мэдэхээс өмнө, та хэзээ ч хийхгүй гэсэн зүйлээ баг багаар хийж эхэлж байдаг. Анхандаа бүх юм зүгээр харагддаг, санагдана. Гэвч нэг л мэдэхэд тийм биш болсон байдаг.

-Бизнесийнхний хувьд луйврын шинжтэй ямарваа үйл ажиллагаануудад оролцох гэж буй эсэхээ мэдэх сэрэмжлүүлгийн шинж тэмдэгүүд нь юу байдаг вэ?

-Үнэн байхад дэндүү итгэмээргүй

сайхан санал хэн нэгэн танд тавьсан бол энэ бол луйвэр гэдэг нь илэрхий. Хоёрдугаарт, “мэдрэмжийн шалгалт” гэж би өөрөө нэрлэдэг зүйл байна. Хэрэв тухайн нөхцөл байдал таны сэтгэлд нэг л зөв биш санагдвал магадгүй тэр мэдрэмж чинь үнэн байх магадлалтай. Тиймээс ийм тохиолдолд тухайн асуудлыг сайн мэддэг хуульч, мэргэжилтнээс зөвлөгөө ав. Энэ удаад л хийгээд үзчихье гээд азаа туршчихаж болохгүй.

-Монголчууд таны алдаанаас юуг суралцаж болох вэ?

-Миний ажил амьдралаасаа олж авсан хамгийн үнэтэй сургамж бол эрх мэдэл, борлуулалтын нөлөөлөл. Монголын хувьд өөрсдийн тухай түүхээ зөв зохистойгоор хүргэж чадахгүй байгаа асуудал дээрээ л сайн ажиллах хэрэгтэй байна. Энэ бол том асуудал. Өөрийн бизнесээ хяналтаасаа гаргаж, зогсохооргүй болгосон нь миний алдаа байсан. Та бүхэнд ч өссөн, уруудсан сургамж бий. Үүнийгээ ашигла. Хяналттай бай.

-Та Монголын хөрөнгийн биржийн өнөөгийн байдлыг хэрхэн харж байна вэ? Бид хэрхэн хөрөнгийн зах зээлээ хөдөлгөж, сайжруулах вэ?

-Монголын хөрөнгийн зах зээлийн хувьд дотоодынхоо зах зээлд суурилдаггүй, итгэл үзүүлдэггүй оршиж байна. Хууль өөрчлөгдөж гаднын хөрөнгө оруулагчид мөнгөө татсан тухайн үеийн уналтаас та бүхэн дөнгөж өндийж байна. Тэгээд Лондонгийн хөрөнгийн бирж орж ирээд төлбөр тооцооны дүрмүүдийг өөрчилсөн. Гэвч одоо ч засаж сайжруулах дүрэм журам, зохицуулалт байна. Гэхдээ үүнээс илүүтэй, дундаж монгол хүний амжилтын талаарх ойлголтод философийн суурь өөрчлөлт, шилжилт хэрэгтэй байна. Та бүхэн өөрийн хөрөнгийн зах зээлдээ, улмаар эдийн засагтаа итгэл үзүүлдэг байх нь чухал. Тийм биш бол амжилтад хүрнэ гэдэг юу л бол.

Та хэвлэлийн бага хурлын үеэр Монгол эдийн засгийн хөдөлгүүрээ эргүүлэн асаахад “мөс хагалагчид” хэрэгтэй байна гэж хэлсэн. Тэгвэл үүнийгээ илүү тодорхой тайлбарлаж өгөхгүй юу?

Хурдасгуур. Тухайлбал, дэлхийд нэрд гарсан томоохон компаниудын нэг Монголд орж ирж үйл ажиллагаа явуулах гэж байгаа талаарх

мэдээллийг олон улсад хүргэж болно. Энэ нь эргээд олон улсыг Монголын талаарх сонирхлоор “цэнэглэж” эхэлнэ. Энэ нэг боломж. Нөгөө талаас монголчууд өөрсдөө бусдад нутаг орноо танилцуулж, зөв талаас нь ярьж өгч, хөрөнгийг татах замаар хэрэгжих боломжтой. Тиймээс эдийн засгийн хөдөлгүүрээ дотроос нь мөн гаднаас нь асааж болно. Ямартай ч асах нь гарцаагүй.

Монголчууд өнөөдөр хөрөнгө оруулагчдыг татахыг ихээхэн чармайж, олон улсын чанартай уулзалт чуулган зохион байгуулж, бас очиж оролцож байна. Энэ нь хэр үр дүнтэй арга бэ. Таны хэлээд байгаа зөвлөгөөтэй нийцэж байна уу?

Мэдээж хэрэг зөв. Ер нь олон улсын томоохон компаниудыг авчрах нь их чухал. Гаднын хөрөнгө оруулалтын урсгалыг сайжруулахын зэрэгцээ тэдгээр хөрөнгө оруулагчид танай улсын баялгийг эзэрхийлэн, тоноод явахгүй байх тал дээр хяналттай байх нь зүйн хэрэг. Тиймээс гэрээний зүйл заалт хоёуланг нь ижил тэгш үйлчлэх ёстой. Монголын газрын доорх баялаг, түүний цар хүрээг тооцоод үзсэн ч гаднын хөрөнгө оруулалт сэргэх нь тодорхой. Энэ тал дээр ахиц гаргахаар ихэд хичээж байгааг би харж байна. Эдийн засгийн энэхүү хурдасгуур нь байгаа оноход хугацаа л хэрэгтэй.

-Хөрөнгө оруулагчид боломж, урт хугацааны өгөөж өндөр байгааг мэдэж байгаа. Гэхдээ Засгийн газрын тааварлаж үл болох үйл ажиллагааг саад гэж харж байгаа энэ нөхцөлд бид хэрхэн тэднийг татах вэ?

-Хоёр талын хувьд байгуулсан гэрээг тогтвортой хадгалж, аль аль талаас асуудалгүй мөрдөх нь чухал. Компаниуд 68 хувийн гэнэтийн ашгийн татвар төлөхийг хүсэхгүй. Гаднынхан хөрөнгө оруулахад таатай нөгөө талаас Монголын ард түмэн бүрэн хамгаалагдсан тогтолцоог гаргаж ирж, нөхцөл байдлыг тэнцвэржүүлэх нь Засгийн газарт тийм хэцүү биш. Хөрөнгө оруулагчдын хувьд татварын орчин савласан, тогтворгүй байхад л хамгийн дургүй байдаг. Хэрвээ одоо та бүхэн зөв хөдөлж, ард нь Засгийн газар чинь зогсож чадвал гаднын хөрөнгө оруулалт эргээд л ирнэ. Өнөөдрийн хувьд цаг хугацааны л асуудал. ■

СТРАТЕГИЙН ОРД

АШИГТАЙ ХУВИЛБАРЫГ НЬ СОНГО

Цагаан суваргаас дутахааргүй орд бол Асгат. Энэ ордыг үе үеийн Засгийн газар эргэлтэд оруулна гэдэг ч төдийлэн ажил болон хэрэгждэггүй. Н.Алтанхуягийн Засгийн газрын үед ч энэ асуудал мөн яригдаж байна. Тэд эдийн засгийг 100 хоногт эрчимжүүлнэ хэмээн 70 ажил хийхээр төлөвлөөд байгаа. Үүн дотроо “Асгатын мөнгөний орд”-ын үйл ажиллагааг эхлүүлнэ гээд тусгачихаж.

С.АЗ

Манай улсад 2005 оноос хойш уул уурхай эрчимтэй хөгжиж эхэлсэн. Газрын доорх баялаг маань гаднынханд Монголыг сонирхох, хөрөнгө оруулах сэдлийг төрүүлж, олон улсад таниулаад байгаа. Энэ эгзэгтэй үед төр засаг хууль эрхзүйн орчноо тогтвортой байлгаж, хөрөнгө оруулагчдыг татах шаардлага бий болоод буй. Учир нь, уул уурхай ДНБ-ий 20, улсын төсвийн 30-50 хувийг бүрдүүлдэг учраас бид хүссэн хүсээгүй энэ салбараа өөд нь татах шаардлага үүсээд байгаа юм. Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан суваргын зэс молибдений ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Монголын алт” компани эзэмшдэг. Тус компани 2001-2008 онд өөрийн хөрөнгөөр нарийвчилсан хайгуул хийж, 2009 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар нөөцийн тайлангаа хэлэлцүүлэн баталгаажуулжээ. Үүгээр 250.4 сая тонн хүдэр, 66167 тонн молибден, 11.127 тонн алтыг улсын бүртгэлд бүртгүүлсэн байна. Харин хайгуулын ажилд тус компани 2.679.400 ам.долларыг зарцуулсан бол нөхөн төлбөрт 714.760 ам.долларыг төрд төлжээ.

Юун 350 сая ам.доллар вэ

Уг ордын 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшихээр Засгийн газраас тогтоолын төсөл боловсруулж УИХ-д өргөн мэдүүлээд байна. Тус төслийн нийт хөрөнгө оруулалт 1031.2 сая ам.доллар. Үүний 34 хувь нь 350.6 сая ам.доллар болж буй аж. Энэ нь шүүмжлэл дагуулж байна. Учир нь, дээрх мөнгийг бонд гаргах замаар эх үүсвэрийг нь шийдэх аж. Тэгэхээр улсын өр дахиад нэмэгдэнэ гэсэн үг. Энэ талаар УИХ-ын гишүүн Н.Энхболд “Засгийн газар хөрөнгөгүй,

чадваргүй мөртлөө хариуцлага, эрсдэл хоёрыг өөр дээрээ наах ямар хэрэгтэй юм. Түрүүчээсээ бид сургамж авах хэрэгтэй. Хамгийн ойрхон жишээ татахад, “Энержи ресурс” компани өөрийн хөрөнгөөр төмөр зам барьж байхад төр дарамталсаар байгаад булааж авсан. Үүнээс болж төмөр зам барих ажил зогссон. Хэрвээ тэр ажлыг төр зогсоогоогүй бол 2012 оноос хойш тэд өөрөө хариуцлага, эрсдэлээ үүрээд төмөр замыг ашиглалтад оруулах байв. Төр хувь эзэмшихээ болих хэрэгтэй. Төрийн хувь их ч бага ч байсан дарамт үзүүлдэг. Тиймээс 350.6 сая ам.долларыг өөр зүйлд хөрөнгө оруулсан нь дээр байх” хэмээсэн.

МАК компани ч төрийн оролцоог оруулах сонирхолгүй байгаагаа нэг бус удаа илэрхийлсэн. Гэтэл Засгийн газар заавал хувь эзэмшинэ гэж улайраад байгаагийн цаад учир шалтгаан юу вэ. Хувийн хэвшил өөрийн хөрөнгөөрөө бүтээн байгуулалт хийж байхад саад тотгор учруулснаар бид хожиж байгаагүй. Аливаа асуудалд улстөржихгүйгээр хандвал хөрөнгө оруулалт татах боломж бийг судлаачид хэлдэг. УИХ-аар баталсан 27 дугаар тогтоолоор стратегийн ордуудыг тодорхойлжээ. Түүнд Цагаан суваргын орд багтсан байдаг. Тэгэхээр хуулиар бол Цагаан суваргын ордод төр 34 хүртэл хувь эзэмших эрхтэй гэж эрх баригчид дээрх үйлдлээ тайлбарлах. Гэтэл 34 хувийн үнэлгээ болох 350.6 сая ам.долларыг оруулсан даруйдаа үр шимийг нь хүртэж чадахгүй шүү дээ. Гэсэн ч Д.Ганхуяг сайд “Энэ төсөл 17 жил үргэлжилж, 11 их наяд төгрөгийн борлуулалт хийнэ гэж гарсан. Төр дангаараа эсвэл аль нэг компани дангаараа орд эзэмших нь утгагүй зүйл. Тиймээс 34 хүртэлх хувийг төр эзэмших нь олон талын ашигтай гэж бид үзсэн. Татвараас гадна ногдол ашиг авна. Мөн төрийн эзэмшлийн хувийг нээлттэй компанийн зарчмаар зохион байгуулна. »

Тогтоолд зааснаар төрийн эзэмшлийн хувийг “Эрдэнэс МГЛ” ХХК-д эзэмшүүлэхээр зааж өгсөн” гэв.

Ямартай ч УИХ-аар төр Цагаан суваргад хувь эзэмших ёстой хэмээн үзэж, тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт нь бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд нь шилжүүлээд байна. Хэрэв тогтоолын төсөл батлагдлаа гэхэд Засгийн газар энэ оны хоёрдугаар улиралд багтаан бонд гарган шийдвэрлэхээр төлөвлөж.

“Асгатын мөнгөний орд”-ыг эргэлтэд оруулж чадах уу

УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолоор баталсан стратегийн ордууд

Д/д	Ордын нэр	Ашигт малтмалын төрөл	Байршил	Тайлбар
1	Тавантолгой	Чулуун нүүрс	Өмнөговь, Цогтцэций	Тавантолгой ХК, Энержиресурс ХХК, Дайцуки ХХК-ийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн хэмжээнд нөөц тооцсон талбайг хамааруулна
2	Нарийн сухайт	Нүүрс	Өмнөговь, Гурвантэс	Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан
3	Багануур	Хүрэн нүүрс	Улаанбаатар Багануур	Нөөц тооцсон талбайг хамааруулна. “Багануур” ХК олборлодог
4	Шивээ Овоо	Хүрэн нүүрс	Говьсүмбэр, Шивээговь	Нөөц тооцсон талбайг хамааруулна. “Шивээ Овоо” ХК олборлодог
5	Мардай	Уран	Дорнод, Дашбалбар	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн бөгөөд хувийн хөрөнгөөр нэмэлт хайгуул хийж байна.
6	Дорнод	Уран	Дорнод, Дашбалбар	
7	Гурванбулаг	Уран	Дорнод, Дашбалбар	
8	Төмөртэй	Төмрийн хүдэр	Сэлэнгэ, Хүдэр	Уг ордын тусгай зөвшөөрлийг “БЛТ” ХХК эзэмшиж байсныг 2006 онд цуцалсан. Нөөц тооцсон талбайг хамааруулна
9	Оюутолгой	Зэс, молибдени	Өмнөговь, Ханбогд	Ордын нөөцийн тооцоо бүхий тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэхэд бэлтгэж байна. Бүлэг ордын хэмжээгээр ойлгоно
10	Цагаан суварга	Зэс, молибдени	Дорноговь, Мандах	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн бөгөөд хувийн хөрөнгөөр нэмэлт хайгуул хийж байна.
11	Эрдэнэт	Зэс, молибдени	Орхон, Баян-Өндөр	Монгол Улс-ОХУ-ын Засгийн газар хоорондын гэрээгээр зохицуулагдаж байгаа.
12	Бүрэнхаан	Фосфорит	Хөвсгөл, Алаг-Эрдэнэ	Хөвсгөлийн их дархан цаазат газрын гадна ногдох нөөц тооцогдсон хэсэгт дөрвөн компани хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг
13	Бороо	Алт	Сэлэнгэ, Баянгол	Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан
14	Төмөртэйн овоо	Цайр, хар тугалга	Сүхбаатар, Сүхбаатар	Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан
15	Асгат	Мөнгө	Баян-Өлгий, Ногооннуур	Монгол, ОХУ-ын Засгийн газар хоорондын гэрээ бүхий хамтарсан Монголросцветмет нэгдэл тусгай зөвшөөрлийг нь эзэмшиж байгаа

Эх сурвалж:

Д.Ганхуяг хариуцаж байгаа аж.

Тус ордод хийсэн геологи, хайгуулын ажлын үр дүн, техник эдийн засгийн урьдчилсан үнэлгээ, тооцоолол болон холбогдох бусад судалгааны мэдээ материалаар хангаж ажиллах үүргийг Төрийн өмчийн хороо, “Монголросцветмет” компанийн удирдлагуудад хүлээж. Уул уурхайн яам Асгатын мөнгөний ордыг ашиглах ажлыг эхлүүлэх нь манай улсад тулгамдаад байгаа эдийн засгийн хүндрэлийг даван туулах, экспортын шинэ нэр төрлийг бий болгох, валютын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзсэн байна. Гэтэл “Монголросцветмет” компаниас энэ ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эхлүүлэх санхүүгийн боломж одоогоор байхгүй гэсэн байна. Учир нь, өнгөрсөн оны дунд үеэс жоншны үйлдвэрлэл зогссон, гол худалдан авагч ОХУ худалдан авалтаа зогсоосноос борлуулалт эрс буурсан, БНХАУ-д тээврийн тариф өссөн болон татварын хэмжээ өндөр, ашиглаж байсан алтны ордуудын нөөц дууссан, зарим орд нь хуулиар хориглосон талбайн хүрээнд багтсан гэжээ.

Тиймээс “Асгатын мөнгөний орд”-ын дээжид технологийн шинжилгээ хийлгэх, орд ашиглах төслийн ТЭЗҮ боловсруулах, төслийн нэгжийг санхүүжүүлэх боломж “Монголросцветмет” компанид байхгүй гэж Засгийн газар үзэн төслийн нэгж байгуулан ажиллах шаардлагатай гэсэн байна. УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолоор энэ ордыг Стратегийн ач холбогдолтой ордод хамааруулсан. Тус орд улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн геологи, хайгуулын ажлаар нөөц нь тогтоогдсон учир Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ордын 50 хүртэл хувийг Монголын төр эзэмших эрхтэй гэж үзээд байна.

Мөн ордыг эргэлтэд оруулах талаар хоёр улсын Засгийн газрын комиссын хуралдаанаар ярилцсан гэх. Гэхдээ чухам ямар журмаар хэн нь хэдэн хувийг эзэмших эсэх нь тодорхойгүй байна. Хойд хөршийн талд уг ордыг ашиглах сонирхол байсаар ирсэн ч дорвитой “хөдөлгөөн” хийж байгаагүй гэдэг.

Хэрэв дээр дурьдсан ажлууд үр дүнтэй байвал манайх өмнөх алдаануудаасаа сургамж авч, өөрсдөдөө ашигтай хувилбарыг сонгох нь чухал юм. ■

DISCOVER MONGOLIA

WELCOME BACK

Энэ бол ирэх есдүгээр сарын 4-5-нд болох “Discover Mongolia-2014”-ийн уриа. Монголын уул уурхайн салбарынхны дунд нэр хүнд, цар хүрээ, туршлагаараа хамгийн томд тооцогддог тус чуулга уулзалтыг Монголын уул уурхайн үндэсний ассоциаци 12 дахь жилдээ зохион байгуулах гэж байна. Чуулганыг “Прайм инфо” компани, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци, Уул уурхайн яам хамтран зохион байгуулах аж.

2002 оноос хойш зохион байгуулагдаж буй энэхүү чуулган нь Монгол Улсын уул уурхай эрдэс баялгийн салбарыг дэлхий нийтэд сурталчлах, хөрөнгө оруулагчдыг өөрийн улсад татах зорилготой гэдгийг хэн хүнгүй мэднэ. Энэ үүргээ ч нэр төртэй биелүүлж, жилээс жилд тус чуулганд оролцогсдын тоо өсөж, чанар сайтай болдог. Гэхдээ өнгөрсөн намрын “Дисковер”-т оролцогчдын тоо огцом багасаж хөрөнгө оруулагчид Монголоос алсарч байгаа нь мэдрэгдсэн. Хэдий тийм ч хөрөнгө оруулагчдад бүхий л талын мэдээллийг өгдөг. Хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа компаниудад тэдэнтэй хамтрах аж ахуйн нэгжүүд тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүний төрөл бүрийн үзэсгэлэнгээ дэлгэдэг бүс нутагтаа тэргүүлэгч уг чуулга уулзалт моодноос гараагүй. Харин ч энэ удаа тэд хөрөнгө оруулагчдыг эргэж ирэхийг уриалж байна. Тиймээс ч уг арга хэмжээг зохион байгуулагчид чуулганд эртнээс анхаарч эхэлжээ.

“Discover Mongolia -2014”-ийн Зохион байгуулах хорооны нарийн бичгийн дарга П.Энхжин “Discover Mongolia чуулга уулзалтыг илүү өргөн цар хүрээнд зохион байгуулна. Өөрөөр хэлбэл, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичиг, Ашигт малтмалын тухай хуулийн өөрчлөлтүүдтэй холбоотойгоор төр засгийн төлөөллийг түлхүү оролцуулахыг зорьж байна. Тиймээс хамтран ажиллах гэрээг Уул уурхайн яамтай байгуулсан юм. Чуулга уулзалтын нээлтэд Ерөнхий сайд оролцоно. Энэ жил бид хэд хэдэн сэдвийг хөндөн илтгэл хэлэлцүүлэхээр төлөвлөөд

байна” гэв.

Энэ удаа “Discover Mongolia”-аар гадаадын шууд хөрөнгө оруулалтыг эх орондоо дуудах. Үүний тулд томоохон ордууд, шинэ төслийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж. Мөн эрчим хүчний шинэ эх үүсвэр болох занар, уран зэргийн талаар нухацтай ярилцах аж. Түүнчлэн урьдчилсан байдлаар гаргасан хөтөлбөрөөс харахад Оюутолгой болон Монголын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны тухай. Мөн Уул уурхайн яамнаас Ашигт малтмалын тухай хуулийн бодлогын өөрчлөлттэй холбоотой илтгэлүүд тавигдах аж. Энэ удаа тэд нүүрсний салбарыг онцгойлон авч ярихаар төлөвлөж буй. Учир нь ойрын гурван жилд Хятадын зах зээл дэлхийд тэргүүлэх таамаг бий. Үүнийг дагаад манай нүүрсний өрсөлдөх чадварт нөлөөлж, үнэ өсөх байх гэсэн хүлээлттэй холбоотой ажээ.

Хоёр өдөр үргэлжлэх уг чуулга уулзалтаар нийт үндсэн найман сэдвийг хөндөх юм. Үүнд Хууль, эрх зүйн орчин, Монгол Улсын нүүрсний экспорт, Зүүн хойд Азийн ашигт малтмалын эрэлт хэрэгцээ ба Монгол Улс, Геологи хайгуул, Уул уурхайн төслийн санхүүжилт, Уул уурхайн төсөл ба төрийн оролцоо, Орон нутгийн засаг захиргаа ба иргэдийн оролцоо гэсэн үндсэн илтгэлүүд багтаж байгаа аж.

Илтгэлийг төр, ТББ, орон нутгийн засаг захиргаа, судалгаа, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчид тавих юм.

Мөн энэ удаагийн “Discover Mongolia”-г Уул уурхайн яам хамтран зохион байгуулж байгаа тул яамны холбогдох албан тушаалтнуудаас Ашигт малтмалын болон бусад хуулиудын талаар хүссэн мэдээллээ авч болох юм байна.

Чуулга уулзалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.discovermongoliaforum.com цахим хуудаснаас авах боломжтой. ■



АШИГТ МАЛТМАЛ

ГАЗРЫН ТОС: АШИГ, ОРЛОГО, ЭРСДЭЛ, БҮТЭЭМЖ

С.ЗАЯА

Газрын тос дэлхий дахинд стратегийн бүтээгдэхүүнд тооцогддог. Учир нь, түүнээс шатахуун гаргаж авдаг нь бусад улсаас эдийн засгийн хараат байх хамгийн гол хөшүүрэг юм. Тиймээс өөрт байгаа энэ баялгаа хэрхэн зөв ашиглах вэ гэх шаардлага бидний өмнө үүсээд буй. Манай улс газрын тосны багагүй нөөцтэй. Тодруулбал, 348 сая тонн орчим газрын тостой. Энэ нь газрын тостой дэлхийн 98 орноос 36 дугаарт бичигдэх дүн аж. Улсын хэмжээнд газрын тосны хайгуулын 31 талбай ялгаснаас өнөөдрийн байдлаар Засгийн газраас баталсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 16 компани 18 талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс “Тосон-Уул XIX”, “Тамсаг-XXI” компанид “Петро Чайна Дачин Тамсаг”, БХГ-97 талбайд “Доншен газрын тос /Монгол” компани хайгуул, олборлолт явуулж байгаа юм. Манайх 1993-2013 оны байдлаар хайгуулын үйл ажиллагаанд нийт 1.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ. Харин 1998-2013 оны хооронд нийт 19.36 сая баррель буюу 2.6 сая газрын тос олборлосноос 2.48 сая тонныг нь урд хөршид экспортолсон байна. Энэ салбараас нийт 520 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

“Төөрсөн” нефтийн үйлдвэр

Манайх ОХУ-аас шатахууны хараат. Тиймээс байсхийгээд шатахууны үнэ нэмэгддэг. Үүнийг дагаад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өсч, ард иргэдийн амьдралд дарамт болсоор ирсэн. Энэ асуудлыг бага ч атугай шийдвэрлэх зорилгоор Дархан-Уул аймагт Нефть боловсруулах үйлдвэр барихаар болсон. Үйлдвэрийн байршил нь буруу гэсэн маргаан одоо ч гарсаар байгаа. Манайх дотооддоо шатахууныхаа хэрэглээг хангах зорилгоор барьж буй хэр нь Дорнодын Матадаас хамаагүй хол Дархан-Уул аймагт үйлдвэр барихаар шийдсэн нь өвсөн дундаас зүү хайхтай адил явдал болов. Үйлдвэрийн хүчин чадал нь ч их. Жилийнхээ шатахууны хэрэгцээг хангах нүсэр байгууламж хэзээ ашиглалтад орох нь тодорхойгүй байсаар. Тодруулбал, Засгийн газраас өнгөрсөн оны нэгдүгээр сард жилд 14.3 сая баррель буюу хоёр сая тонн тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр барихаар тогтоол гаргажээ.

Гэтэл манай улсын газрын тос агуулах боломжтой сав газрууд нь нутгийн зүүн, өмнөд, баруун өмнөд хэсэгт


тархсан байхад үйлдвэр байгуулах Дархан-Уул аймаг нутгийн хойд хэсэгт байрладаг. Тэгэхээр тээвэрлэлтийн зардал өснө гэсэн үг. Хэрэв үйлдвэрийн түүхий эдээ хойд хөршөөс хангана гэвэл тэд зарах тосныхоо үнийг аажим аажмаар нэмэх болно. Түүхий эдийн хомсдолоос болж үйлдвэрээ зогсоох уу, эсвэл өндөр зардал гарган дотоодоосоо зөөх үү гэх ацан шалаанд орох нь. Үүнээс гадна үйлдвэр барьсан хөрөнгөө эргээд зээл авсан газартаа төлж таарна. Одоогоор энэ үйлдвэрийг Япон улсын хөрөнгө оруулалтаар урт хугацааны бага хүүтэй зээлээр барихаар төлөвлөөд байгаа.

Манай улсын нефтийн бүтээгдэхүүний жилийн хэрэгцээ 2016 он гэхэд 12.9 сая баррель буюу 1.8 сая тоннд хүрэх тооцоог эдийн засагчид гаргажээ. Энэ талаар хайгуулын геологич, доктор Д.Буян-Арвижих “Нүсэр байгууламж бус жижиг үйлдвэрүүдийг оновчтой байрлалуудад байгуулах ёстой. Улмаар ирээдүйд нээгдэх нөөцөн дээрээ тулгуурлан үйлдвэрүүдээ өргөтгөөд явбал хамгийн оновчтой байх байсан” гэв.

Хууль батлагдсанаар бүх зүйл шийдэгдэх үү


Газрын тосны тухай хуульдаа манайх 1991 оноос хойш салхи оруулаагүй. Тэгвэл энэ удаагийн УИХ-аар тус ▶

Газрын тосны олборлолт, экспорт



Эх сурвалж: Газрын тосны газар

Газрын тосны хайгуулын талбай



► хуулийг шинэчлэн найруулахаар хэлэлцэж байгаа. Уг нь оны өмнө Засгийн газраас өргөн мэдүүлсэн дээрх хуулийн төслийг хууль тогтоох байгууллага өнгөрсөн сарын 15-ны хуралдаанаараа эцсийн хэлэлцүүлэг хийж, батлахын даваан дээр санал тэнцсэнээр унасан юм. Тиймээс Засгийн газар гишүүдийн гаргасан зарим зүйл заалтыг тусган УИХ-д дахин өргөн мэдүүлээд байна. Ингэхдээ өмнө нь хэлэлцэж байсан хуулийн төсөлд тусгасан сайн зүйл заалтуудыг тодорхой бус болгосон гэх. Энэ талаар УИХ-ын гишүүн Х.Болорчулуун “Өмнөх хуулийн төсөлд бүтээгдэхүүн хуваах гэрээний 50-иас доошгүй хувийг Монгол Улс эзэмшинэ, хайгуулын зардлаа нөхсөний дараа 60 хувийг эзэмшинэ гэж заасан байсан. Харин одоо гэрээнүүдэд өөрчлөлт оруулахгүй, Бүтээгдэхүүн хуваах гэрээний асуудлыг тоо тавихгүйгээр Засгийн газар шийднэ гэсэн байна. Ийм зүйл заалтаар баталж хэрхэвч болохгүй” гэв.

Үүнийг мэргэжлийн холбоод нь буруутгаж байна. Учир нь, тус салбарын хайгуул эрсдэл өндөртэй аж. Хайгуулын ганцхан цооног өрөмдөхөд хэдэн сая ам.доллар шаардагддаг гэх. Тэр нь хоосон байх нь энүүхэнд аж. Тиймээс манайх шиг жижиг орны хувьд төр нь оролцохгүйгээр санхүүгийн эрсдэл үүрэх чадвартай хувийн хэвшилд даатгаж, тухайн компанийн олборлох тосноос татвар, оногдох хувиа авах нь ашигтай гэдгийг Газрын тосны ассоциацийн төлөөлөл хэлсэн.

1991 онд батлагдсан Газрын тосны тухай хуулиар зарчмын шинжтэй харилцааг зохицуулсан бол Засгийн газрын 1991 оны 204 дүгээр тогтоолоор баталсан Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмаар газрын тосыг хайх, олборлохтой холбоотой гол харилцааг зохицуулжээ. Өөрөөр хэлбэл, газрын тосны хайгуул, олборлолт, үнэлгээ, төлбөр, газрын түрээс, татвар, захиргааны үйлчилгээний шимтгэл, нягтлан бодох бүртгэл, бүтээгдэхүүн хуваах, татвараас чөлөөлөх зэргийг тусгажээ. Харин хуульд газрын тосны олборлолт явуулж буй аж ахуйн нэгжүүдийн харилцааг нарийн тусгаагүй, ойлгомжгүй, бусад хуультай зөрчилдсөн заалтууд олон байгаа аж. Энэ харилцааг Засгийн газрын тогтоолоор баталсан журмаар зохицуулж буйгаас хамаарч

дээрх хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл учирч эхэлжээ. Иймээс Газрын тосны тухай хуулийг бүхэлд нь шинэчлэн найруулж, газрын тос, байгалийн хий, уламжлалт бус газрын тосны талаарх ойлголтыг нэг мөр болгох аж. Мөн төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээг тодорхой болгон, роялти, татварын хувь хэмжээ, түүнийг оногдуулах, хөнгөлөх, чөлөөлөх, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар ч хуульд нарийвчлан тусгах юм байна.

2000 оноос хойш хийсэн бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг өөрчлөөд байх шаардлагагүй гэнэ. Учир нь, бүгдийг нь сонгон шалгаруулалтаар хийсэн байдаг аж. Өөрөөр хэлбэл, хоёр талд харилцан ашигтай хийсэн гэрээнүүд юм байна. Харин 1993 оны бүтээгдэхүүн хуваах гэрээг засч өөрчлөхөөс өөр аргагүй гэдгийг газрын тосны салбарынхан хэлсэн. Уг гэрээ манай улсад их хэмжээний алдагдалтай. Энэ гэрээгээр манайх нийт бүтээгдэхүүнийхээ 24-хөн хувийг хүртэхээр байгаа аж. Гэтэл дэлхийн жишигт бүтээгдэхүүн хуваалтыг аливаа ашгийн 50-иас дээш хувийг тухайн улс нь хүртдэг юм байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээний анхны загвар орон болох Индонез 71 хувийг хүртдэг Норвеги 78 хувийн татвар авдаг байна. Өөрөөр хэлбэл, Норвегичүүд татварын бодлогоороо зохицуулж, ашгаа шингээж өгчээ.

Бид 20 жилийн өмнө алдагдалтай гэрээ байгуулсан байж болно. Үүнийгээ засах хэрэгтэй. 1993 оны гэрээ Тогтвортой байдлынх бус бүтээгдэхүүн хуваах гэрээ гэдгийг УИХ-ын гишүүн Х.Болорчулуун хэлсэн. “Дачин Тамсаг”-ийн XIX талбайгаас байгалийн нөөц ашигласны татвар авдаггүй аж.

Газрын тосны салбар эрэл хайгуул их, өртөг өндөртэй ч зөв ашиглабал улс орны эдийн засгийг тэтгэх бүрэн боломжтой. Тиймээс эрх баригчид улстөржихгүйгээр Газрын тосны тухай хуулиа чамбай баталвал хөрөнгө оруулагчдыг татах хөшүүрэг болох аж. Учир нь манайд зах зээл бий. Нефтийн бүтээгдэхүүний хэрэглээгээр дэлхийд тэргүүлдэг улсуудын нэг болох Хятадтай хил залган оршиж буй боломжоо ашиглан оновчтой хувилбарыг нь сонгох шаардлага үүсээд байна.

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN
ECONOMY

www.mongolianeconomy.mn

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл-14 хоног тутам



СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИД
ЗАХИАЛГА БАЙНГА АВНА
УТАС: 7011 5476

ҮНЭГҮЙ
ХҮРГЭНЭ

ТОМИЛОЛТ

ЦОГТЦЭЦИЙГЭЭС ГАШУУНСУХАЙТ



МОНГОЛ УУ, ХЯТАД УУ

Түрүүч нь №09,10 (67, 68)

С.БАТЗАЯА

Чанга яригчаар “Юань авна, маргааш боомт руу хүн авч явна” хэмээн хятад аялгатай хоолойгоор монголоор зарлахыг сонсоод бухимдал төрөв. Монгол хүн эх нутгийнхаа газар шороон дээр явж байж Хятадын ядуусын хороолол дунд буй мэт орчинтой нүүр тулахад өөрийн эрхгүй эгдүүцдэг юм билээ. Энэ газарт гол төлөв нимгэн гөлмөн төмрөөр хоёр эгнээ үүсгэн байшин барьж, /бидний ярьж занснаар сэндвичэн барилга/ дунд нь өргөн гудамж гаргажээ. Хайш яйш загвар ур хийцтэй байшингуудын ихэнх нь хүнс, барааны дэлгүүр аж. Дэлгүүрүүдийн хаалган дээр “юань авна”, “узель товчоо”, “мах хямд худалдана” гэсэн зарыг хятад, монголоор бичсэн байх. Урд хөршөөс орж ирсэн жимс жимсгэнэ, бараанууд лангуун дээр овоорсон харагдана. Байшингуудын дундах шороон замаар суудлын тэрэгнүүд тоос татуулан зөрөх. Гудамжаар хөлхих хүмүүсийн нэлээдгүй нь хятад байх юм. Дэлгүүрийн лангууны ард хятад бүсгүйчүүд сууж байх нь хэвийн үзэгдэл. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Цагаанхаданд буй дүр зураг иймэрхүү. Гэхдээ энэ зөвхөн уг суурин газрын төв хэсэг гэдгийг тодотгох нь зүйтэй байх.

“Энержи ресурс”, “Эрдэнэс Тавантолгой” компанийн гаалийн хяналтын бүстэй хаяа дэрлэн орших айлууд лав 200 орчим байгаа. Хөө торгонд даруулсан гэрийн гадна цайны

газар, малгай, цамц, ажлын хувцас зарна гэсэн хаяг байх. Нэгэнт хүн ам төвлөрсөн учраас Ханбогд сум “Хайрхан” баг байгуулсан ч засаг захиргаагүй мэт хэн дуртай нь хаа тааралдсан газраа гэр, амбаар, чингэлэг гээд дотор нь эд зүйл хийж болох бүхий л зүйлийг хөглөрүүлчихэж. Үүнийгээ сум орон нутгаас холбогдох албан тушаалтан ирж бидэнтэй уулзаж байгаагүй. Долоо хоног бүр ирж хог ачна гэдэг ч одоо хүртэл сураггүй. Хогийн цэг гаргасан ч нэмэр болоогүй хэмээн тайлбарлах. Эндээс Хятадын Ганцмодны боомт хүртэл 25 орчим км. Тэд өмнө нь монголчуудаас яс их хэмжээгээр авч байсан учраас зарим айлын гадаа энэ зүйл овоолоостой харагдана. Говь халуун бүгчим, дээрээс нь урин дулааны улирал ирсэн болохоор ч тэр үү яснаас ойр орчимд нь хүн байхын аргагүй өмхий үнэртэх аж.

Орхигдсон багийнхныг “тоогооч”

Өдөр шөнөгүй нүүрс тээврийн машинууд явдгаас эндхийн аж амьдрал хэрхэн өрнөдгийг өмнөх сурвалжлагадаа өгүүлсэн. Уурхайгаас Гашуунсухайт боомт хүртэл нүүрс тээвэрлэхэд олон салаа зам гарснаас газрын хөрс эвдрэх, малын бэлчээр талхлагдах нь хэвийн үзэгдэл болжээ. Зөвхөн Тавантолгойгоос Цагаанхад хүртэлх 230 гаруй км замын хоёр талаар нийт 35250 га газрын хөрс эвдэрсэн гэх судалгааг холбогдох байгууллагуудаас гаргасан байна. ▶

ХҮРТЭЛХ СААРАЛ АМЬДРАЛ-4



► Мөн Мэргэжлийн хяналтын төв, орон нутгийн болон Цаг уур орчны шинжилгээний газар, Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори зэрэг газраас уул уурхайн үйл ажиллагаа төвлөрсөн бүс нутгийн иргэд хөрс, агаар, усны бохирдлын ямар орчинд амьдарч буйг судалж. Үр дүн нь Цагаанхадан дахь гаалийн хяналтын талбайн орчны агаар стандартад заасан хэмжээнээс 45 дахин, нарийн ширхэгт тоосонцор 34-35 дахин их байгаа нь тогтоогджээ.

Энэ судалгааг шороо тоос дийлдэхгүй учраас өглөө өмссөн хувцас өдөртөө тас хар болдог. Тоосжилтоос үүдсэн өвчин эмгэг их. Багийн эмчтэй болчихвол тус нэмэртэй юм. Амьдралын боломжтой хэд нь жилдээ нэг удаа аймагтаа очиж эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамрагддаг. Бусад хэсэг нь нүдэн балай чихэн дүлийн явдаг гэх нутгийн иргэдийн яриагаар баталгаажуулж болох.

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас Өмнөговь аймагт нүүрс тээвэрлэлтийн улмаас учирсан хохирлын хэмжээг тодорхойлсон судалгаанд аймгийн эдэлбэр газарт 5.4, хөрсөнд 20.4, ургамалд 11.1, амьтны аймагт 18.7, агаарын бохирдлоос үүссэн хохирол 2.5 тэрбум төгрөг нийт 58.1 тэрбум төгрөгийн хохирол учирсан хэмээн дурьджээ.

Энд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн харьцангуй өндөр үнэтэй юм. Худалдаа эрхлэгч Ш.Дэлгэрбатынх Гашуунсухайтын боомт 1992 онд түр ажиллагаатайгаар байгуулагдах үеэс Цагаанхаданд суурьшжээ. Тэрбээр “Уул уурхайн тээвэрлэлт явагдаагүй байхад газрын хөрс сайхан байж. Том оврын машинууд өдөр шөнөгүй хөлхисөөр ийм байдалд хүрсэн. Манайх сэлбэг барилгын материалын дэлгүүр ажиллуулдаг. Валютын ханшийн зөрүү худалдаа наймаанд ихээр нөлөөлөх болсон. Бараагаа Гашуунсухайт боомт болон Эрээнээс татдаг” гэв. Амьжиргааны өртөг өндөр, мөн тээврийн зардлаа шингээх зорилгоор бараагаа хотын ханшаас илүү үнээр худалдаалдаг байна. Уул уурхай

эрчимтэй явж буй үед 1000 орчим хүн амьдардаг гэнэ. Суурин байдаг нь 200 гаруйхан.

Ус магнаг болжээ

“Хайрхан” баг эрчим хүчинд холбогдоогүй. Энэ нь тэндхийн уугуул суугуул иргэдийн хамгийн тулгамдсан асуудал аж. Зарим нь мотор асаадаг бол боломжтой хэд нь нарны толь, сэнс урд хөршөөс оруулж ирэн угсарч, цахилгааны эх үүсвэр татдаг байна. Гэрэл цахилгаангүй айл олон учраас гар утас цэнэглэх бичил “бизнес” цэцэглэжээ. Нэг удаа утас цэнэглүүлэхэд 1500 төгрөг. Хажуугийн айлдаа цахилгаан ашиглуулахад өдрийн 5000 төгрөгийн ханштай. Бэл бэнчингүй хэд нь ойролцоох айлаасаа тог авч хүч хүрэхгүй. Тэдэнд сард 150 орчим мянган төгрөг төлөх нь бүү хэл хоногийн хоолоо залгуулах нь халаг болдог аж. Оюутолгой руу Хятадаас өндөр хүчдэлийн шугам татжээ. Тэр шугамаас Цагаанхад руу татах боломж байсан ч ийм хувилбарыг нь сонгоогүй. 10 гаруй мянган хүн эргэлддэг хэр нь ямар ч хөгжил дэвшил байхгүй хэмээн нутгийн иргэд өгүүлж байв. Нээрээ ч тийм юм. Хятадын Ганцмодны боомтын хөгжлийг Гашуунсухайт, Цагаанхадтай харьцуулахад тэнгэр газар шиг ялгаатай аж. Цагаанхаданд цагаан тоос манаран нүүгэлтэж, олон машин зөрөхөд сул шороо ойр орчмын газрыг хэсэгтээ л харанхуйд автуулж байхад урд хөршид эсрэгээрээ. Тэд энэ асуудлаа хэрхэн шийдсэнийг нь манай холбогдох албан тушаалтнууд судалмаар юм шиг санагдсан.

Гашуунсухайт, Цагаанхаданд усны асуудал хүндрэлтэй. Нэг литр ус 30-45 төгрөгийн үнэтэй. Ойр орчмын булаг шанд, худгууд ширгэсэн учраас иргэд 1-5 тонн-ын чингэлэг машин дээрээ ачин суурингаас 15-20 км-ын зайд байрлах гар худгаас ус авчирч зардаг аж. Ийм “бизнес” хийдэг иргэд хоногийн хоолныхоо мөнгийг өлхөн олчихдог гэх. Нийслэлийн гэр хороололд литр ус нэг төгрөгийн үнэтэй. ►►

▶ Тэдний хажууд бид ч “Уух ус яанаа гэж санаа зовохгүй жаргаж байгаа юм байна даа” гэх бодол төрөв. Хүн, мал амьтан ундаалах усгүй болвол эд хөрөнгө, баялагтай байгаад ч яах билээ. Говь угаас ус ховортой газар. Үүн дээр уул уурхайн эрчимтэй хөгжил байгаль орчныг доройтуулж, гол горхи, булаг шанд, худаг ширгэхэд нөлөөлсөн гэж хэлж болох. Ус нь давс, хужир ихтэй учир ундандаа хэрэглэхэд бас л учир дутагдалтай аж. Үүнээс өөр сонголтгүй учир хэрэглэдэг гэх. Нэг өрх өдөрт дунджаар 50-60 литр ус хэрэглэдэг байна.

Цагаанхаданд өдөр бүр 6-7 тонн-ын ёмкостоор ус авчирч зардаг айл байдаг аж. Тэд өвөлжөөнөөсөө ус зөөж, иргэдийн усны хэрэгцээг хангаж байгаа гэнэ. Үүнийгээ тэд худаг гэж нэрлэх. Эднийх литр усыг 30 төгрөгөөр худалддаг бол машин дээрээсээ “усны бизнес эрхлэгчид” 40-45 төгрөгөөр худалдана. Худаг ажиллуулдаг гэх Д.Нэргүй “Хөдөө байдаг гүний худгаасаа усаа авдаг. Хүн ихтэй үед 2-3 удаа явж усаа татна. Худаг ажиллуулаад хоёр жил гаруй

болж байна. Бид гадуур зарагдаж байгаа уснаас харьцангуй хямд үнээр зардаг. Гэсэн ч өдрийн орлого сайтай байдаг юм. Дунджаар өдөрт 60-100 мянган төгрөгийн орлоготой ажилладаг” гэв. Амралтын өдрүүдэд үүнээс ч илүү орлоготой байдаг гэх. Ус ийм үнэтэй байгаа ч ховор байсан үеэ бодвол олдоц сайтай болсон хэмээн нутгийн иргэд ярих.

Эх орны маань нэгээхэн хэсэг Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Цагаанхаданд амьдрал ийм байна. Монголын нүүрсийг урд хөрш рүү экспортлох нэрэн доор хятадууд олноор ирж суурьшсан нь дэндүү харамсмаар. Монгол Улс хүн амзүйн бодлого, гадаадын иргэдэд тавих хяналтаа алдаж байна уу даа гэж бодохуйд харуусах, харамлах, эмтрэх сэтгэл төрж, зүрх шимширч байлаа. Элсээ магтдаг говийнхон эд эс нь болсон газар нутгаа үеийн үед уламжлуулан үлдээгээсэй. Үүнд хүнээ, улсаа гэсэн сэтгэл зүрхтэй шийдвэр гаргагчдын оролцоо чухал гэдгийг тэмдэглэмээр байна. ■

ОЮУТОЛГОЙ

АЮУЛГҮЙ БАС ДАХИН АЮУЛГҮЙ

Э.ЗОРИГТ

“Mongolian Economy” сэтгүүлийн сурвалжлах баг энэ удаа орон нутгийн томилолтоороо Оюутолгойн уурхайд ажиллалаа. Та бүхэнд тус уурхайн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа болон бүтээн байгуулалтын сурвалжлагыг хүргэж байна. /2014.05.21-22/

Уйлагнасан тэнгэр, хаврын сэрүүн өдрүүдэд дассан хотын бидэнд өмнийн говийн салхи нь хүртэл халуунаар сэвэлзэж эгээ л уурын зуух шиг санагдана. Нүд алдам талын дунд торойх “Ханбумбат” олон улсын нисэх онгоцны буудлаас Оюутолгой уурхай руу явах замд “Аюулгүй ажиллагаа бол хүн бүрийн үүрэг хариуцлага мөн” гэсэн тод томруун бичиг нүднээ тусав.

Их бүтээн байгуулалт эхлэхээс авахуулаад өнөөдрийг хүртэл Оюутолгойг зорьсон сэтгүүлчдийн баг олон. Энэ удаа харьцангуй цөөхөн сэтгүүлч, цагт нэг их шахагдахгүй явж байгааг тус компанийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн ажилтан

С.Энхцэцэг аяллын эхэнд онцолсон. Өглөө ажилдаа инээмсэглээд гарсан аав орой эсэн мэнд үр хүүхдэдээ ирэх эсэх нь баталгаагүй уул уурхайн үйлдвэрлэлд “Рио Тинто” аюулгүй ажиллагааг алхам тутамдаа мөрдлөг болгодог ороо онцлог. Тийм болохоор Оюутолгойн сайтад зочилсон хэн боловч тэрхүү дүрэм журамд суралцан, өөрийн болон өрөөлийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Аюулгүй ажиллагааны талаар өгөх зааварчилгаа дүрэм журам нь нэлээд тэвчээр шаардах ажил. Оюутолгойн сайтад зочилж байгаа л бол хэн ч байсан аюулгүй байдлын анхан шатны мэдлэг олгох 20-30 орчим минутын сургалтад суухаас дэлхийн дайтай уурхайтай танилцах аялал эхэлдэг уламжлалтай. Сургалтаар онцгой байдлын үед “Muster point” буюу цуглах газар гэсэн ногоон өнгийн тугтай газар цуглах. Аюул ослын болоод шаардлагатай үед залгах 9904-3333 дугаарыг цээжлэх. Дугаарыг мартсан тохиолдолд энгэрээсээ хоромхон ч холтгож болохгүй нэвтрэх үнэмлэхний ар дээр бичсэн байдаг гээд юун түрүүнд мэдэх шаардлагатай зааварчилгааг энд өгнө. Харин төслийн талбай дээр ажиллахаар очиж буй шинэ ажилтанд бол аюулгүй ажиллагааны тусгай ▶



сургалтыг 2-3 хоног хийдэг байна. Мөн зочин болгон Оюутолгой руу нэвтрэх тусгай үнэмлэх авахаас гадна уурхайтай танилцах бол хамгаалалтын тунгалаг шил, цацруулагчтай хантааз, ширэн гутлаар тоноглогдоно.

Болохгүй гэдэг үг олныг сонссон зочдын дараагийн зочлох газар бол ус цэвэршүүлэх үйлдвэр байсан юм. Ус агуулах болон цэвэршүүлэх гэсэн үндсэн хоёр блокоос бүрдэх тус үйлдвэрт ороход сэрүү татах нь нэн таатай. 2011 онд ашиглалтад орсон уг үйлдвэр ахуйн, ундны, савласан, галын гэсэн дөрвөн төрлийн ус үйлдвэрлэдэг. “Oyu Asis” гэсэн 10 литрын савлагаатай усыг зориулалтын тавиур дээр эгнүүлжээ. Өнгөрсөн оноос эдгээр саванд ус савладаг болжээ. Гүний хоолойн усны орд газраас татсан усыг үйлдвэрт ундны болон ахуйн гэсэн хоёр хэсэгт хуваан цэвэршүүлдэг аж. Үйлдвэрийн Ашиглалтын инженер Б.Энхцэцэгийн хэлснээр говийн ус Улаанбаатарынхаас бараг 4-5 дахин өндөр эрдэсжилттэй байдаг тул ундны усны стандартын шаардлага хангахгүй, ахуйн хэрэглээнд ч тохиромжгүй дарагдмал ус байдаг аж. Харин тус үйлдвэрт энэхүү үйлдвэрийн зориулалттай усыг тусгай шүүлтүүрээр шүүж ундны усны зориулалттай болгодог байна. Ахуйн зориулалттай усны хувьд ариутгал халдваргүйжилт буюу хлоржуулалт хийгддэг гэсэн.

Оюутолгойн ахуйн усны хэрэглээ хоногт 500-600 тонн. Ундны усны хоногийн хэрэглээ 50-60 тонн аж. Тус үйлдвэр хоногт ахуйн болон ундны хэрэгцээний 500 тонн ус цэвэршүүлэх хүчин чадалтай. Мөн цэвэршүүлсэн усыг шинжлэх тусгай лабораторитай. Лабораторийн

шинжилгээгээр чанарын шаардлага хангаагүй усыг дахин боловсруулдаг. Цэлгэр том, цэмцгэр үйлдвэрийг барьж байгуулахад мэдээж хэдэн тэрбумаар тоологдох хөрөнгө орсон нь илт. Бидэнд инженер, лабораторийн ажилтнууд үйлдвэрийг танилцуулсан учраас хөрөнгө оруулалтын тухай хөндөөгүй юм. Ямартай ч уурхайн олон мянган ажилтан, говьд эрүүл ахуйн баталгаатай цэвэр цэнгэг усаар хангагдаж байгаа нь сайн зүйл. Зөвхөн Оюутолгойн ажилчдад биш, Ханбогд сумын иргэдэд мөн савласан усны үйлчилгээг хүргэдэг байна.

Эрүүл хоол эрч хүч

... “Сайн хүн явсан аа. Муу хүн идсэн ээ” гэдэг дээ. Гэхдээ Оюутолгой руу явсан хэн ч тэндэхийн хоолны талаар ам ангайхгүй байж чадахгүй л болов уу. Уурхайн ажил хүнд хэцүү. Дээрээс нь говийн эрс тэс цаг агаарт хоол, нойр хоёр сайн байхгүй бол ажлын бүтээмж тэгийг зааж мэднэ. Оюутолгой компанийн хувьд энэ нь зайлшгүй мөрдөх зүйлсийн нэг. Тийм ч учраас эндэхийн хоолны чанар сайн, сонголт арвин. Хоолны газар нь Монгол, Европ гэсэн хоёр хэсэгтэй. Зууш, жимс, талх нарийн боовноос тааллаараа сонгох боломжтой. Өдрийн гурван хоолтой. Хоолны өрөөний хаа сайгүй эрүүл хооллох болон хүний өдөрт авах ёстой илчлэгийн хэмжээг харуулсан заавар зөвлөмж өлгөөтэй. “Таны тавганд юу байна вэ” гэх ханын самбарт сонгож байгаа хоол тань хоорондоо хэр зохицох талаар зөвлөсөн байх жишээтэй. Огт өөх тосгүйгээс эхлээд монголчуудын зооглох дуртай өөх тостой хоолыг ч хийсэн байдаг. Эндхийн хоолны үйлчилгээг олон улсын SIS компани хариуцан ажилладаг.

Эрүүл мэндийн паспорт

Оюутолгойн эмнэлэг, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээний төв болох эмнэлгийн үйлчилгээний байр нь тун тохилог, цэвэрхэн. Оюутолгойн эмнэлгийн үйлчилгээг 2004 оноос олон улсын SOS эмнэлэг хариуцан ажиллаж буй. Урьдчилан сэргийлэх үзлэг болон анхан шатны тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх зорилготой учраас энд гаднын сургагч эмч нар ажилладаг. Биед нь зовиур илэрсэн хэн ч хэдэн ч цагт үзүүлэх боломжтой. Нарийн мэргэжлийн эмч нараас гадна сэтгэцийн эмч хүртэл ажилладаг. Оюутолгойн талбайд ажиллаж байгаа бүх ажилтнуудад тус эмнэлгээс “Эрүүл мэндийн паспорт” нээж өгчээ. Эмнэлгийн зүгээс тухайн хүний суурь шинжилгээг оношилж тогтоохоос гадна уг дэвтэрт эрүүл мэндээ сайжруулахад чиглэсэн мэдээлэл, авах арга хэмжээ, хяналтын тэмдэглэлийг багтаасан байдаг аж. Мөн хүн бүрт алхалт хэмжих аппарат “бэлэглэнэ”. Оюутолгойн эмнэлгийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Гантулга “Эмэгтэй хүн өдөрт 8000, эрэгтэй хүн 10.000 алхсан байвал зохист хөдөлгөөн хийсэн гэж үздэг тул энэхүү алхалтын аппаратыг манайх хүн бүр зүүхийг зөвлөдөг” гэв. Эм, эмнэлгийн хэрэгслээ АНУ, Сингапураас авдаг байна. Өдөртөө тус эмнэлэгт дунджаар 50-60 хүн ханддаг аж. Ханбогд сумын иргэдэд ч шаардлагатай тохиолдолд эмнэлгийн үйлчилгээ хүргэдэг байна. ▶



Фотог Э.Зоригт

Оюутолгой компани аюулгүй ажиллагааныхаа талаар сэтгүүлчдэд танилцууллаа



Ил уурхайн туузан дамжуурга

Аюулгүй

Оюутолгойд “Комацу”, “Катерпиллар”-ын хүнд даацын 30-аад машин механизм өдөр шөнөгүй ажиллана. Монголд ердөө хоёрхон байдаг гинжит дугуйтай, аварга том ачигч машины нэг нь ч мөн уг уурхайд бий. Ил уурхайн хүнд машин механизмын засвар, үйлчилгээний төв 2011 онд ашиглалтад оржээ. Тус төвд мөрдөгдөх аюулгүйн дүрмүүдийг тодорхой өнгөөр ялгаж Засварын цехийн талбайг будсан байх тул тэрхүү зай талбайд ямар зориулалттай ажил хийгддэг нь хүн бүрт тодорхой. Шар өнгийн талбайгаар зөвхөн явган хүн, цэнхэр хэсэг нь засвар хийгдэх машин техникт зориулсан байх жишээтэй. Засвар үйлчилгээний төвтэй танилцаж байгаа бидний хувьд шар хэсгээс хэтрэх эрхгүй. Хэрвээ аюулгүйн бүсээс гарвал засварын төвийн ажилчид тэр дор нь эелдгээр таныг заасан хэсэгт очихыг сануулна. Ер нь Оюутолгойд хэн нэгэн аюулгүй ажиллагааны дүрмээ зөрчиж байвал хэн ч байсан шаардлага тавих эрхтэй бөгөөд үйл ажиллагааг нь шууд зогсоох дүрэмтэй. Уурхайн эргэн тойронд “Оюутолгойд хүн бүр аюулгүй ажиллагааг хангах үүрэгтэй”, “Хэн нэгэн өөрт болон өрөөлд аюул учруулах эрсдэлтэй ажил хийж байвал түүнийг зогсоох эрх нь хүн бүхэнд нээлттэй” гэсэн үг өгүүлбэр бүхий зурагт самбаруудыг нүдэнд харагдахаар газруудад байрлуулсан харагдана. Энэ нь нэг талаар “Аюулгүй бас дахин аюулгүй” гэсэн тэдний туйлын зорилгыг хэрэгжүүлэх чухал алхам болдог аж.

Засвар, үйлчилгээний төвийн бүх ажилчид хувийн цоож, нэр, утасны дугаар бүхий пайзтай. Ажлаа хийх үедээ тэрхүү хувийн цоож, пайзаа засварлаж байгаа тоног төхөөрөмжид өлгөж ажлаа гүйцэтгэнэ. Энэ нь тухайн хэсэгт ямар үйлчилгээг хэдэн засварчин хийж байгааг мэдэгдэх үүрэгтэй гэсэн. Мөн цоож, пайзаа өлгөөгүй хүн тухайн ажиллах орчинд ойртох эрхгүй. Энэ нь ажил гүйцэтгэж байх үед санамсаргүй байдлаар эрсдэл үүсэхээс хамгаалдаг. Оюутолгойн аварга техникүүдийн засвар үйлчилгээг “Трансвест” компани хариуцан ажилладаг. Тус компанийн ажилтнууд асар туршлагатай Австрали мэргэжилтний удирдлагад аюулгүй ажиллагааг ханган ажилладаг. “Трансвест” компанийн Аюулгүй

ажиллагааны мэргэжилтэн Б.Гантулга “Би өдөр бүр өөрийн болон хамт ажилладаг хүмүүсийн гэр бүлийнхээ сайн сайхны тухай боддог. Бид ажилдаа эрүүл саруул ирсэн бол гэртээ харихдаа ч гэсэн амар амгалан, аюулгүй буцах нь чухал. Тиймээс аюулгүй ажиллагааны дүрмээ ягштал биелүүлэх хэрэгтэй” гэсэн юм. Оюутолгойн сайтад автомашин 5-7 км/ц хурдтай, өдрийн цагаар ч гэрлээ асааж явах ёстой. Аюулгүйн бүсээ бүслэх, заасан замаас өөр замаар явахгүй байх, туслах замаас орж байгаа бол заавал зогсож шулуун замын хөдөлгөөнийг харна гээд олон арван аюулгүй байдлын мөрдлөг нь байгууллагын дүрэм журмаас гадна гэр бүл, хайртай дотны хүмүүсийнхээ өмнө хүлээсэн хариуцлага хэмээн оюутолгойчууд ойлгож, өдөр тутмын ажилдаа хэвшил болгохыг зорьдог нь хүн бүрийн хандлагаас мэдрэгдэнэ. Хүнд нөхцөлд ажиллах аюулгүйчид болон үйлдвэрийн ажилчид 28 хоног ажиллаад 14 хоног амардаг журам нь мөн л хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж буй хэрэг гэсэн юм.

Ил уурхай

Аяллын багийн танилцах хамгийн сонирхолтой хэсгийн нэг бол яах аргагүй ил уурхай. Тойргийн диаметр нь нэг км орчим бөгөөд 130 гаруй метр гүн ил уурхай эртний Грекийн гладиаторуудын тулалддаг цэнгэлдэх мэт харагдана. Тээр дор 300 тоннын даацтай “Комацу” маркын хүнд даацын машинд эксковатор хүдрийн баяжмал шанагадан хаяна. Ачаатай, ачаагүй том тэргүүд өөдөө сөргөө зогсолтгүй хөлхөнө. Энд дунджаар долоо хоногтоо гурван удаа тэсэлгээ хийнэ. Тэсэлсэн хүдрийг “Комацу” зөөж, холгүйхэн орших анхдагч бутлуурт буулгана. Анхдагч бутлуур уулын чулуулгийг ойролцоогоор 25 см-ээс бага хэмжээтэй болгож жижиглэдэг байна. Жижиглэсэн хүдэр туузан дамжуургаар урсаж баяжуулах үйлдвэрийн эхний дамжлагат хүрнэ. Анхдагч бутлуураас баяжуулах үйлдвэр хүрдэг туузан дамжуурга 2.7 км-ын урттай. Ил уурхайн Уулын олборлолтын ахлах ажилтан Б.Гантулга “Ил уурхай 20 жилийн дараа 500-600 метр гүнзгийрэх бол тогооны нь урт 2.7 км, өргөн 1.5 км болохоор тооцоолсон. Оюутолгойн баялгийн ихэнхийг далд уурхай хэлбэрээр олборлохоор байгаа” гэв. ▶



► Ил уурхайд өдөртөө 100, шөнөдөө 80-аад хүн ажилладаг байна. Зэсийн агууламж нэг хувь байгаа. 300 тоннын даацтай нэг машин хүдэр нэг хувийн зэсийн агууламжтай гэсэн үг. Зөвхөн зэс биш, алт, мөнгө гээд бусад металл ч бий. Хоногтоо дунджаар 200.000 тонн хүдрийг анхдагч бутлуурт буулгадаг байна.

Гол хэсэг

Чих дөжрөм чимээ шуугиан дунд ганц хоёрхон алхмын зайтай яваа хүмүүс нэгнийгээ сонсоход бэрх. Дээрээс нь говийн бүгчм агаарын температур энд даруй хоёр дахин нэмэгдчих вүү гэлтэй. Оюутолгойн баяжуулах үйлдвэрийн аварга тээрмүүд хүчтэй эргэлдэж, хүчит мотор зогсоо зайгүй ажиллаж байгаа болохоор ийм халуун, тийм чимээтэй байх нь аргагүй гэдгийг үйлдвэрийн ажилчид учирласан. Аварга тээрмүүд хүржигнэн эргэлдэж байгаа нь анхдагч бутлуураас ирсэн хүдрийг нунтаглаж, 0.3 см диаметртэй болгож байгаа хэрэг юм. Баяжуулах үйлдвэрийн хамгийн анхны дамжлага нь энэ. Баяжуулах үйлдвэрийн тээрмүүд хүчин чадлаараа Ази тивдээ хоёрдугаарт, дэлхийд эхний тавд эрэмбэлэгддэг аж. Анхны дамжлагаар өдөрт 100 мянган тонн хүдэр нунтаглах хүчин чадалтай. Гэхдээ одоогоор өдөрт 70 мянга орчим тонн хүдэр нунтаглаж байгаа гэсэн. Эхний дамжлагаас гарсан хүдрийг арай бага овортой дөрвөн тээрэм 150 микрометр болтол нунтагладаг байна. Энэ хүрээд хүдэр нунтаглах үйл явц дуусна. Гурил шиг нунтаг болсон хүдэр дараагийн дамжлага руу шилжинэ. Баяжуулах гэдэг нь эхний хоёр дамжлагаас гарсан нунтаг хүдрээс зэс, алт, мөнгийг нь ялгаж авах дамжлага. Ялгаж авахын тулд хөвүүлэн баяжуулах аргыг хэрэглэх бөгөөд том торхонд хийсэн хүдрийг тусгай химийн аргаар “буцалгадаг” аж. Буцлах явцад хөөсрөх хэсэгт алт, мөнгө, зэс нь наалдан дэвэрч, түүнийг нь тусгай хамагч хамж зориулалтын сувгаар урсгана. Товчхондоо хүдрийн хэрэггүй хэсэг нь лаг шавар болон торхны ёроолд тунадаг бол зэс, алт, мөнгө нь хөөсөнд наалдан хөвөн гарч ирж тусгай суваг руу урсана. Тухайн баяжмалыг шүүж уснаас салгадаг аж. Үүнийхээ дараа зэсийн баяжмалыг туузан дамжуургаар агуулах руу тээвэрлэнэ. Тэндээс хэд хэдэн шат дамжлагаар явсаар савлагааны хэсэгт хүргэгддэг. Энд баяжмал маань хоёр тоннын даацтай цагаан өнгийн шуудайнд савлагдсанаар сая экспортод гарах визээ даруулна. Уутлагдаад гараад ирэх үед мэргэжлийн байгууллагуудын дээж авах цул цагаан хувцастай шинжилгээний багийн мэргэжилтнүүд ажиллана. Тэд хоёр дахь шуудай бүрээс дээжлэх аж.

Харин баяжуулах үйлдвэрээс хэрэггүй хэсэг урд зүгт байрлах дугуй хэлбэрийн хоёр байгууламжид хүргэгддэг гэнэ. Тэр нь хүдрийн хаягдал лагийг өтгөрүүлэх, усыг нь шүүрүүлэн авах хэсэг. Учир нь үйлдвэрлэлд ашигласан усыг дахин ашиглахын тулд энэ хэсэгт авчирдаг. Эндээс гарсан усыг дахин ашиглах хэсэгт аваачдаг. Одоогоор Оюутолгойн баяжуулах үйлдвэр нийт ашигласан усныхаа 80 гаруй хувийг дахин ашиглаж буй.

Тайлбарлахад ч хэцүү баяжуулах үйлдвэрийн энэ

бүх үйл явцыг тусгай өрөөнөөс 3-4 хүн цахим орчинд удирдан, хянаж байдаг юм билээ. Тонг төхөөрөмжийн засвар, баяжмалыг савлах болон ачихад л гар ажиллагаа оролцохоос бусдаар бүгд компьютерийн удирдлагатай.

Согтуу шил



Ил уурхайн хүнд машин механизмын загвар, үйлчилгээний төв

Баяжуулах үйлдвэрээс гараад “Эрсдэл үзүүлэх сургалтын төв”-д ирэв. Ийм сургалтын төвтэй уурхай дэлхийд цөөхөн байдаг гэдгийг Аюулгүй ажиллагааны мэргэжилтэн Б.Долгион онцолсон. Уг төвийг Хөдөлмөрийн аюулгүй орчин, осол гэмтэлгүй нөхцөлийг дээд зэргээр бүрдүүлэх зорилгоор 2013 онд байгуулсан байна. Энд уурхайн ойр орчимд учирч болзошгүй бүхий л аюул эрсдэлийг тооцоолон нүдэнд харагдахуйц, гарт баригдахуйц байдлаар үзүүлэх ажээ. Тухайлбал, үйлдвэрлэлийн бүхий л тоног төхөөрөмж цахилгаан, эрчим хүчтэй холбогддог учир энэ тал дээр Оюутолгойн аюулгүйн ажиллагаа нарийн дүрэм журамтай. Мөн согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үед хүний биед гардаг өөрчлөлтийг мэдрүүлдэг тусгай шил хүртэл энд бий. Согтууруулдаг шилийг зүүгээд тэгшхэн шугамыг дагаж алхах шиг хэцүү зүйл үгүй. Мөн тухайн шилийг зүүгээд удирдлагатай машиныг жолоодож, согтуу машин баривал ямар байдгийг үзэж дэлгүүтэж ч болно. Түүнчлэн аюулгүй ажиллагааны УХААН-ы талаар богинохон хичээлийг энд заадаг.

Тэр нь:

Урьдаар нарийн тооц

Хор хөнөөл, аюул бүрийг тодорхойл

Аюул дагуулсан эрсдэлийг таньж мэд

Аюул хөнөөлийг хяна

Нэн тэргүүнд аюулгүй байдлаа ханга гэсэн таван өгүүлбэрээс бүрдэх УХААН мөрдлөг юм. Энэ бүхний эцэст ажилдаа ирэхдээ осол гэмтэлгүй ирсэн бол гэртээ харихдаа ч гэсэн тийм л байх хэрэгтэй гэх Оюутолгойнхны алтан дүрмийн дагуу бүтэн хоёр өдөр аюулгүй аялсан сурвалжлагаа хүргэлээ.

Далд уурхай нэгэнт зогссон учраас бидэнд сонирхуулахыг хүсээгүй. Бусад бүтээн байгуулалтын талаар олон зүйлийг бичмээр байгаа ч энэ хүргэж өндрөлөөд, фото сурвалжлагаар хүргэе. ■

НОМЫН БУЛАН

ХҮМҮҮН ЦАДИГ

... Арван дөрөвтэй хүүгийн ажлын хөлс, сарын нийлбэр дүнгээрээ нэлээд их мөнгө болчихно. Тэр цагийн ханшаар мянга гаран төгрөгийн шагнал бичигдчихсэн байх энүүхэнд. Улсыг Аюулаас хамгаалахын байцаагч, ахлах офицер хүний сарын цалин 350 орчим төгрөг, малын зах дээр нас гүйцсэн эр хонь 30 төгрөгийн ханштай байсан гээд бодохоор тэр цагтаа шаггүй их цалин! 33 бүдүүн эр хонь авчих мөнгийг сарын шагналдаа авна гээд ойролцоогоор бодохоор өнөөгийн ханшаар зургаан сая 600 мянган төгрөг авсантай тэнцэх нь! Гэтэл үйлдвэрийн захиргаа Доржсүрэнг хүүхэд гээд их мөнгө өгөхгүй. Жаахан хүүхдэд тийм их цалин өгчих нь тэр үеийн зарчимд нийцэхгүй байсан хэрэг. Тэр ч бүү хэл, шагнал цалинг нь комбинатын захиргааны шийдвэрээр хаачихсан байж.

-Жаахан хүүхдэд ийм их мөнгө өгч яаж болох вэ. Хар багаас нь мөнгөний шуналтан болгож эвдэх нь..! гэж хурал дээрээ хэлэлцсэн нь тэр. Харин энэ бүхэн еврей удамтай, орос мэргэжилтэн Рачуновт таалагдсангүй. Тэр хүн арван дөрөвхөн настай слесарьтаа их сайн байсан учраас захиргаа руу гүйж очив.

-Та нарт ичих нүүр алга уу? Жаахан хүүхдийн шагналын цалинг яагаад хаачихаж байгаа юм бэ? Насанд хүрээгүй, юугаа ч мэдэхгүй хүүхдийг луйвардсантай ялгаа алга! гэж уурлан бөөн хэл ам хийлээ. Дарга нар өнөөх тайлбараа хэлж, ятгаж сэнхрүүлэх гэж оролдсон ч, еврей эр бууж өгөлгүй үзэлцсээр байгаад хүүгийн шагнал цалинг хагас дутуу ч болов олгуулах

шийд гаргуулж байж. Тэр үед орос мэргэжилтэн гэдэг их эрх дархтай, эвэртэн туурайтнуудыг айлгаж чаддаг хүмүүс байсан хэрэг...Энэ бол зохиолч А.Амарсайханы “Арван дөрөвтэй том хүн” зохиолын хэсэг.

Тэртээ 1930-аад онд долоон

дарханы сургууль дүүргэж байгаагаар үйл явдал өрнөж байна. Харин номын өрнөл хэсэгт Г.Доржсүрэн 14 насандаа Аж Үйлдвэрийн комбинатад ажилчин болж, улмаар 18 насандаа олзны япончуудыг даргалан ажиллаж, 20-иодхон насандаа Аж үйлдвэрийн комбинатын ерөнхий механик, орлогч даргын албыг залгуулсан гээд эгэл амьдралын эгэл бус нэгэн байсныг зохиолч А.Амарсайханы “Арван дөрөвтэй том хүн” номонд элдэв хачиргүйгээр баримтат уран зохиолын аргаар өгүүлжээ. Уг номын гол баатар Г.Доржсүрэн гуай өдгөө 87 настай буурай сэрүүн тунгалаг “Арван дөрөвтэй том хүн” номын нээлтэд том охиныхоо хамт хүрэлцэн ирсэн юм. А.Амарсайханы аав Алтангэрэл гуай номын нээлтийн ёслол дээр хүүгийнхээ туурвисан бүтээлийн гол баатар болох Г.Доржсүрэн гуайд алд цэнхэр хадаг өргөн барьж, хүндэтгэл үзүүлсэн.

Дөнгөж саяхан гарсан “Арван дөрөвтэй том хүн” ном бол “Хүмүүн цадиг” цувралын тэргүүн дэвтэр аж. Уг цувралаа эхлүүлэхээр А.Амарсайхан зохиолч сонин содон амьдралтай хүн асууж, сураглаж, судалгаа хийж байхдаа Хэвлэлийн хүрээлэнгээр санаандгүй ортол МУСГЗ Н.Дариймаа багш маань надад Г.Доржсүрэн гуайн тухай ярьсан. Анхны ярилцлагаас л гол баатрын маань өнгөрүүлсэн амьдрал гайхамшигтай санагдаж, ярианд нь өөрийн эрхгүй шимтсэн гэнэ. Анхандаа “Арван дөрөвтэй том хүн” цадигийн гол баатар Гомбын Доржсүрэн өөрийнх нь амьдралаар ном бичнэ гэсэн чинь халгаадаггүй. ▶

▶ Нилээд ятгасны эцэст цадигийн номоо бичихээр болсон талаараа А.Амарсайхан ах хуучилсан юм.

Гайхам содон амьдрал туулж, энгүй ихийг бүтээсэн хэрнээ эгэл даруу амьдардаг хүн олон. Ийм хүмүүстэй уншигчдыг уулзуулахаар “Хэцүү анги”, “Тусгай салаа”, “Огцом эргэлт”, “Улаан эрэг” хэмээх олон ангит киногоороо үзэгч олныг байлдан дагуулсан зохиолч А.Амарсайхан ах маань “Хүмүүн цадиг” цувралаа ийнхүү эхлүүлээд байгаа нь энэ аж. Тэрбээр “Түүхийн ном зохиолын хуудсанд улс төрч, төрийн зүтгэлтнүүд, сод хүмүүсийн тухай баримтууд дүүрэн хэрнээ энгийн ардын амьдрал ахуй ямар байсныг ховор дурьдаж үлдээдэг юм билээ. Дарга нарын албан тушаалд очсон он сар өдрийг ягштал тоочсон атлаа энгийн ажилчин талхаа хэдэн төгрөгөөр авдаг байсан талаар нэг ч үг үсэг бичээгүй байдаг. Үүнээс нь болоод адрах сэтгэл төрсөн. “Яахаараа энгийн ажилчин хүний туулсан амьдралаар намтар цадигийн ном гаргаж болдоггүй билээ? Тэгэх тусам нь гайхаж алмайртал нь гоё бичих юм шүү!” гэж, зүрх сэтгэлдээ асаж шатаж байж л энэхүү “Арван дөрөвтэй том хүн” номоо бичлээ” гэсэн юм.

Амарсайхан ах мөн “Mongolian Economy” сэтгүүлийн “ажилтан” бидний туурвисан эдийн засгийн хүнд хэцүү, тоо ихтэй нийтлэл, сэтгүүлийн хуудсыг шог зургаар чимэглэдэг. Мөн түүний хөтөлдөг манай сэтгүүлийн мэдээний нүүрний доод талын шог зургийн буланг уншигчид сонирхох дуртай.

“Mongolian Economy” сэтгүүлийг үүсгэн байгуулагдах цагаас эхлээд өнөөдрийг хүртэл үнэнч ажиллаж байгаа зохиолч, сэтгүүлч, шог зураач, багш гээд олон ажлыг зэрэг амжуулдаг Амараа ахдаа манай хамт олон халуун баяр хүргэж, цаашдын уран бүтээлд нь өндөр амжилт хүсье. ■

*Бид шилдгийг
саягасан...*



Бусад нь унтаж байхад чи сурч, бусад нь наргиж байхад чи ажиллаж, бусад нь мөрөөдөж байхад чи анхны алхмаа хий!

Бид бүх шатны сургалтын хөтөлбөрөө зуун хувь гадаад, мэргэжлийн заах арга барилыг эзэмшсэн чадварлаг, манлайлал бүхий багш нартайгаар дэлхийн стандартын түвшинд явуулна. Сургалтаа өвөрмөц арга барилаар явуулж, англи хэлийг төрөлх хэл шигээ эзэмших боломжийг Та бүхэнд олгоно.

English World – Education center нь өөрчлөгдөн хувьсаж буй өрсөлдөөний эрин үед дасан зохицох, манлайлах чадвар бүхий олон төрлийн хөтөлбөр, сургалт үйл ажиллагаа явуулдаг.

СУРГАЛТ:

- Гадаад багштай ганцаарчилсан сургалт
- Гадаад багштай танхимын сургалт /динамик/
- Business Group/10-12 хүн/
- Менежерийн англи хэл /Удирдлагын англи хэл/8-10 хүн/
- Байгууллагын бусад төрлийн захиалгат сургалтууд
- Испани, Португали, Польш хэлний сургалтууд
- Гадаад хэлнээс орчуулгын үйлчилгээ
- Элчингийн ярилцлагад бэлдэх
- IELTS болон TOEFL-ын шалгалтад сүүлийн үеийн хөтөлбөрөөр бэлтгэх

ХОЛБОО БАРИХ:

Утас: 77114567; 94005001

Имэйл: englishworldmongolia@gmail.com

Хаяг: Энх тайвны өргөн чөлөө,

“Пийс” цамхаг/Peace Tower/, VIII давхар, 802 тоот